



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3

- БНМАУ-ын Тэтгэмжийн хууль
- БНМАУ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль
- БНМАУ-ын Башкын хууль
- Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ)

*БНМАУ-ын Бага Хурлын Тамгын Газар*

№ 3

1991 оны дөрөв, тавдугаар сар

(3)

## ГАРЧИГ

### I. БНМАУ-ЫН ЕРӨНХИЛЭГЧИЙН БАТЛАМЖ, БНМАУ-ЫН ХУУЛЬ

Хуудасны дугаар

1. Хууль батламжлах тухай № 12	186
2. БНМАУ-ын Банкны хууль	186
3. Хууль батламжлах тухай № 13	196
4. БНМАУ-ын Тэтгэмжийн хууль	196
5. Хууль хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хууль	203
6. Хууль батламжлах тухай № 14	204
7. Үйлдвэрчний эвлалүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль	204
8. Хууль батламжлах тухай № 15	208
9. БНМАУ-ын нийгмийн даатгалын шийтгэлийн тухай хууль	209

### II. БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

0. Төлөөлөгчөө батлах тухай № 16	211
1. Зарим хүнийг ажлаас чөлөөлөх тухай № 17	219
2. Зарим хүнийг ажлаас чөлөөлсөнд тооцох тухай № 18	219
3. Зорчих, цагаачлах тухай БНМАУ-ын хуулийн төслийн тухай № 21	220
4. Олон нийтийн байгууллагын тухай БНМАУ-ын хуулийн төслийн тухай № 22	221
5. БНМАУ-ын Банкны хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 23	222
6. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны тухай № 24	223
7. Конвенцид нэгдэн орох тухай № 25	225
8. БНМАУ-ын Тэтгэмжийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 26	225
9. Комиссийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай № 27	226
10. Хууль батлагдсантай холбогдуулан авах ярга хэмжээний тухай № 28	227
11. Цалин, хангамжийн тухай № 30	228

22. Лхамын Цэриндондогийг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 43	229
23. Гомбострингийн Дашдэвжээг элчин сайдаар томлох тухай № 44	229
24. Нөхөр Пэрэнлэйн Үржинлэхүндэвийг элчин сайдаар тохосон томлох тухай № 45	230
25. н. Дулмаад БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай № 48	230
26. Нөхөр Ч. Балдарт БНМАУ-ын хүний гавьяат эмч цол олгох тухай № 49	231
27. Зарим хүмүүст БНМАУ-ын гавьяат барилгачин цол олгох тухай № 51	231
28. Ч. Сандрт хошууч генерал цол олгох тухай № 53	232
29. Цагаатгах ажлагч удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийг батлах тухай № 55	233
30. Шашир асуудал эрхлэх зөвлөл байгуулах тухай № 60	236
31. Амьсгал боогдуулах, нууцны асгаруулах тусгай хэргийг хэрэглэхийг хориглох тухай № 61	240
32. Олон нийтийн хэн журам зөрчиж тэнхээрчлэлд хүлээгдэх хариуцлагыг чангатгах тухай № 62	241
33. Өргөн хэрэглэний бараа, хүнсний зүйлсийг хувиарлах, борлуулах ажлагч журамлах, дамын наймаа зийгчлэлд хүлээгдэх хариуцлагыг чангатгах тухай № 63	243
34. Цагдаагийн байгууллагын зарим хүнийг шагнах тухай № 68	245
35. Б. Цэндсүрэнг «Шударга журам» медалиар шагнах тухай № 69	246
36. Зарим хүмүүсийг «Шударга журам» медалиар шагнах тухай № 74	247
37. Дамдинжавын Ганхүүг «Шударга журам» медалиар шагнах тухай № 75	247
38. Товуудоржийн Бямбадоог «Шударга журам» медалиар шагнах тухай № 76	248
39. Зарим сурагчдыг «Шударга журам» медалиар шагнах тухай № 77	248
40. Зарим хүмүүст БНМАУ-ын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 78	249
41. Д. Данзанд БНМАУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 79	250
42. С. Балдоржид БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай № 80	250
43. Нөхөр Ж. Дагвадоржид БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай № 81	251

Эмхтгэсэн Б. Одоожиа  
Техник редактор Б. Оюундаагэр  
Хянагч С. Итгэлт

Зах № 16

Үйлдвэрт шилжүүлсэн 1991 оны 5-р сарын 9-нд,  
Өрөөлөд 1991 оны 5-р сарын 4-нд, Хэвлэлтэд  
1991 оны 6-р сарын 3-нд. Цаасны хэмжээ  
60х90/16. Хэвлэлийн хуудас 4,25. Хэвлэсэн тоо  
10000 ширхэг.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЯЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 4 дүгээр

Дугаар 12

Улаанбаатар

сарны 20-ны өдөр

ЭОУ

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Банкны хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БНМАУ-ЫН БАНКНЫ ХУУЛЬ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

*Нийтлэл үндэслэл*

*1 дүгээр зүйл. Хуулийн зорилт*

БНМАУ-ын Банкны хуулийн зорилт нь БНМАУ дахь банкны тогтолцоог бэхжүүлэх, банкны үйл ажиллагааны эрх зүйн гүндсийг тодорхойлон зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл. БНМАУ дахь Банк*

1. Мөнгөн хөрөнгө хуримтлуулан хадгааж өөрийн нэрийн мөнөөс бусдад зээлдүүлэх, мөнгөн гүйлгээ эрхлэх, харилцах тансны ажил, гүйлгээ явуулдаг байгууллагыг банк гэнэ.

2. Банк төрийн хүлээх үүргийг хариуцахгүй, өөртөө тухайн хүлээгээгүйгээс бусад тохиолдолд банкны хүлээх үүргийг эр хариуцахгүй.

*3 дугаар зүйл. БНМАУ дахь банкны тогтолцоо*

БНМАУ дахь банкны тогтолцоо нь БНМАУ-ын Төв банк, рилжааны банкнаас бүрдэнэ.

#### 4 дугаар зүйл. Банкны гүйлгээ

1. Банк нь дор дурдсан гүйлгээг хийнэ:

- 1) мөнгөн хөрөнгийг дансанд хадгалах, төлбөр тооцоо хийх;
- 2) зээл олгох;
- 3) төсвийн орлого, зарлагыг шинэжүүлэх;
- 4) зээл, төлбөрийн баталгаа гаргах;
- 5) үнэт металл, валют худаадан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;
- 6) гадаад төлбөр, тооцоо хийх;
- 7) үнэт цаас гаргах, худаадан авах, худалдах;
- 8) үнэт зүйл хадгалах;
- 9) хууль тогтоомжоор хориглоогүй бусад гүйлгээ.

#### 5 дугаар зүйл. Хориглох үйл ажиллагаа

Банкинд дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 1) материаллаг үйлдвэрлэл эрхлэх;
- 2) бүх төрлийн лавтгаалын үйл ажиллагаа явуулах;
- 3) газрын зах зээлд ажиллах;

#### 6 дугаар зүйл. Банкны тухай хууль тогтоомж

Банк нь үйл ажиллагаагаа энэ хууль болон БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад акт, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрмийг удирдлага болгон явуулна.

#### 7 дугаар зүйл. БНМАУ-ын мөнгөн тэмдэгт

1. БНМАУ-ын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун мөнгөтэй тэнцэнэ.

2. Төгрөг, мөнгөний хэв загварыг БНМАУ-ын Бага Хурал батална.

3. БНМАУ-ын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх бөгөөд төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг БНМАУ-ын Төв Банкны зөвшөөрлөөр хэрэглэж болно.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### БНМАУ-ын Төв Банк

#### 8 дугаар зүйл. БНМАУ-ын Төв Банкны тодорхойлолт, дүрэм

1. БНМАУ-д мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий амиссийн банкыг БНМАУ-ын Төв Банк гэнэ. БНМАУ-ын Төв Банкыг Монголбанк гэж нэрлэнэ.

2. Монголбанкны дүрмийг БНМАУ-ын Бага Хурал батална.

**9 дүгээр зүйл. Монголбанкны удирдлага**

1. Монголбанкыг түүний Ерөнхийлөгч толгойлно.

Монголбанкны Ерөнхийлөгчийг БНМАУ-ын Засгийн газрын ерөнхий сайдтай санал солилцон зөвшилцсөний үндсэн дээр, БНМАУ-ын Бага Хурлын даргын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Бага Хурал 5 жилийн хугацаатай томилно.

Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг Монголбанкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Бага Хурал 5 жилийн хугацаатай томилно.

2. Монголбанкны Ерөнхийлөгч үйл ажиллагаагаа БНМАУ-ын Бага Хуралд хариуцан тайлаглана.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийн цалингийн хэмжээг БНМАУ-ын Бага Хурал тогтооно.

**10 дугаар зүйл. Монголбанкны салбар**

Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах зорилгоор өөрийн салбарыг байгуулж болно. Салбарын даргыг Монголбанкны Ерөнхийлөгч томилно.

**11 дүгээр зүйл. Монголбанкны үйл ажиллагаа**

Монголбанк төрөөс явуулах мөнгө зээлийн нэгдсэн бодлогыг дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

1) гүйлгээнд байвал зохих мөнгөн тэмдэгтийг хангах;

2) төгрөгийн тогтвортой байдалыг хангах;

3) арилжааны банкны заавал байх нөөцийн доод хэмжээг тогтоох;

4) хүүгийн нэгдсэн бодлого явуулах;

5) эгсийн зөөлүүлэгчийн хувьд арилжааны банкуудад зээл олгох;

6) банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж гүйцэтгэх;

7) Засгийн газрын зөөлөлгийн үйл ажиллагааг явуулах;

8) Засгийн газрын үнэт цаастай холбогдолтой үйл ажиллагааг явуулах;

9) өөрийн тэнцэлд байгаа улсын үнэт металл, валютын нөөцийг хадгалуулах;

10) харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нийт банкны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

11) арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт тавих.

**12 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, гүйлгэвчээс татах**

1. Монголбанк нь мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, татах, гүйлгээнд байвал зохих хэмжээг тогтоох эрх эдэлнэ.

2. Монголбанк нь мөнгөн тэмдэгтийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, түүний нөөцийг бий болгох, төлбөрийн хэрэгсэл мөн эсвхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах ажлыг эрхлэн зохион байгуулна.

3. Гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгтийг Монголбанк өөрийн активаар баталгаажуулна.

*13 дугаар зүйл. Төгрөгийн тогтвортой байдлыг хангах*

Монголбанк нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй. Энэ зорилгоор хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, гүйлгээнд байх мөнгөн тэмдэгтийн баталгаажилт илүү өндөр чанарын активаар (алт, валютуар) баталгаажсан байхаар нэмэгдүүлэх, бусад орны валютын нэгжээр илэрхийлэгдэх төгрөгийн ханшийн бодлогыг зохицуулах, арилжааны банкнаас олгох зээлийн хэмжээг багасгах зэрэг онцгой арга хэмжээ авах эрхтэй.

*14 дүгээр зүйл. Заавал байх нөөцийн хувь хэмжээг тогтоох*

Монголбанк нь арилжааны банкны заавал байх нөөцийн (тухайн банкны кассад байгаа бэлэн мөнгө, Монголбанк, арилжааны бусад банкны дахь харилцах дансанд байгаа үлдэгдэл мөнгөний) хувь хэмжээг мөнгө-зээлийн бодлогод зохицуулан тогтооно.

*15 дугаар зүйл. Хүүгийн нэгдсэн бодлого явуулах*

Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээ, зах зээл дээрх түүний үнэлгээний түвшин, арилжааны банкны заавал байх нөөцийн дутагдсан хэсгийг нөхөх зорилгоор олгосон банк хоорондын зээлийн хүүгийн хэмжээ зэргийг харгалзан Монголбанкнаас (эцсийн зээлдүүлэгчийн хувьд) арилжааны банкинд олгох зээлийн хүүгийн хэмжээг тогтоох замаар хүүгийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

*16 дугаар зүйл. Банк хоорондын төлбөр тооцоо гүйцэтгэх*

Банк хоорондын төлбөр тооцоог тэдгээрийн харилцах дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

*17 дугаар зүйл. Засгийн газрын зээлээгний үйл ажиллагаа*

Монголбанк Засгийн газрын үнэт цаасыг зах зээл дээр борлуулах, түүний үндсэн өр, хүүг олгох ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.

*18 дугаар зүйл. Засгийн газрын үнэт цаастай холбогдолтой үйл ажиллагаа явуулах*

1. Монголбанк нь мөнгө зээлийн бодлого явуулахдаа Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, худалдах үйл ажиллагааны анхдагч хэрэгсэл болгон ашиглана.

2. Засгийн газрын үнэт цаас нь зээлийг барьцаалах баталгаа болно.

19 дүгээр зүйл. Үнэт металл, валютын нөөцтэй холбоотой ажил, гүйлгээ

Монголбанк тэнцэлдээ байгаа улсын үнэт металл, валютын нөөцийг өөрөө болон эрх олгосон банкаараа дамжуулан хадгалуулах, гүйлгээ хийх эрх эдэлнэ.

20 дугаар зүйл. Монголбанкны сан хөмрөг

1. Монголбанк нь өөрийн үйл ажиллагааг явуулахын тулд дүрмийн сан, бэлтгэл сан, бусад сантай байна.

2. Монголбанкны дүрмийн сангийн хэмжвэг БНМАУ-ын Бага Хурал батална.

21 дүгээр зүйл. Монголбанкны тайлан тэнцэл

Монголбанк жил бүр өөрийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан тэнцэл, ашгийн хуваарилалт, орлого, зарлагын төсвийг БНМАУ-ын Бага Хуралд батлуулахаар оруулна.

22 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

БНМАУ-ын Бага Хурал Монголбанкны үйл ажиллагаанд хяналт шалгалт тавина.

23 дугаар зүйл. Монголбанкаас арилжааны банктэй харилцах зарчим

Монголбанк нь хуульд заасны дагуу зохицуулах, хянан шалгах эрхээ хэрэгжүүлэхдээ арилжааны банкны бие даасан байдлыг аадгддуулахгүй байх зарчим баримтлана.

24 дүгээр зүйл. Монголбанкны гадаад харилцаа

1. Монголбанк нь олон улсын банк, гадаадын банк, санхүү зээлийн байгууллаагатай БНМАУ-ын ашиг сонирхолд нийцүүлэн БНМАУ-ын хууль тогтоомж, БНМАУ-ын олон улсын гэрээний дагуу харилцан ажиллана.

25 дугаар зүйл. Гадаадын банк, түүний салбар, төлөөлөгчийн газар байгуулах

1. БНМАУ-ын нутаг дэвсгэрт гадаадын банк, түүний салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох асуудлыг Монголбанкны саналыг үндэслэн БНМАУ-ын Засгийн газар шийдвэрлэнэ.



2. БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадаадын банк БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бод энэ хууль, БНМАУ-ын бусад хуулийг баримтлана.

*26 дугаар зүйл. Ашиг хуваарилах*

1. Монголбанк нь жилийн үйл ажиллагааныхаа явцад бий болсон ашгаас БНМАУ-ын Бага Хурлаас тогтоосон журмын дагуу холбогдох санд шилжүүлж дараа үлдсэн хэсгийг улсын төсвийн орлого болгоно.

2. Монголбанк нь албан татвараас чөлөөлөгдөнө.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Арилжааны банк*

*27 дугаар зүйл. Арилжааны банкны төрөл*

Арилжааны банк нь (цаашид «банк» гэх) дүрмийн сангийн өмчлөлтөөр нийтийн (төрийн) болон хувийн; бий болсон хэлбэрээр хувь шийлүүлсэн, хязгаарлагдмал хариуцлагатай, гадаадын хөрөнгийн оролцоотой, гадаадын; банкны ажла, үйлчилгээ явуулах хэлбэрээр нийтлэг болон төрөлжсөн байж болно.

*28 дугаар зүйл. Банк байгуулах*

1. БНМАУ-д банкыг төсвөөс санхүүждэг болон олон нийтийн байгууллага, улс, нийгмийн ач холбогдолтой энэрэнгүй үйлсийн сан хөмрөг эрхэлдэг байгууллагаас бусад байгууллага, иргэн Монголбанкнаас олгосон зөвшөөрөл (эрхийн бичиг)-ийн үндсэн дээр байгуулна.

2. Монголбанк нь банк байгуулах тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор өөрийн шийдвэрийг албан ёсоор гаргана.

3. Банкыг улсын бүртгэлийн байгууллага бүртгэлд авна. Банк нь улсын бүртгэлийн гэрчилгээ авснаар банкны үйл ажиллагаа явуулах эрхтэй болно.

*29 дугаар зүйл. Банк байгуулахад бүрдүүлэх баримт бичиг*

1. Банк үүсгэн байгуулагч нь банк байгуулах эрхийн бичиг авахын тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлж Монголбанкнд гаргаж өгнө:

1) банк байгуулахыг зөвшөөрөх тухай үүсгэн байгуулагчийн хүсэлт, шийдвэр;

2) банкны дүрэм;

3) банк байгуулах өдийн засгийн үндэслэл;

4) үүсгэн байгуулагчийн төлбөрийн чадварын талаарх холбогдох байгууллаагмын санаа, дүгнэлт.

2. Дээр дурдсан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдвол Монголбанк олгосон эрхийн бичгээ хүчингүй болгож, уг банкны үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргаж нийтэд зарлана.

*30 дугаар зүйл. Банк байгуулах эрхийн бичиг олгохгүй байх үндэслэл*

Монголбанк нь дор дурдсан үндэслэл байвал банк байгуулах эрхийн бичиг олгохгүй:

1) банкны дүрэм нь БНМАУ-ын хууль тогтоомжид харшилж байвал;

2) санхүүгийн чадваргүй бол.

*31 дүгээр зүйл. Банкны дүрэм*

1. Банк нь өөрийн дүрмийг БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдөнө. Банкны дүрэмд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

— банкны оноосон нэр, харьяалаа, хаяг;

— эрхлэх ажил, үйлчилгээний хүрээ;

— дүрмийн сангийн хэмжээ;

— банкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

— татан буулгах журам.

2. Банк дүрмэндээ оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Монголбанкнд мэдэгдэж бүртгүүлнэ.

*32 дугаар зүйл. Банкны салбар нээх*

1. Банк нь Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн тус улсын утаг дэвстэрт өөрийн салбарыг нээж ажиллуулж болох бөгөөд эдгээрийн гүйцэтгэх үүргийг банк өөрийн эрх хэмжээнд багтаан одорхойлно.

2. Банкны салбарыг гадаад оронд нээж ажиллуулах асуудлыг Монголбанк шийдвэрлэнэ.

3. Банкны салбарын үйл ажиллагааны журмыг тухайн банкны аталсан дүрмээр тодорхойлно.

*33 дугаар зүйл. Банкны сан хөмрөг*

1. Банкны дүрмийн сан өөрийн хөрөнгөөс бүрдэнэ. Дүрмийн сан зарласан хэмжээнд байлгана.

2. Банкны дүрмийн сангийн доод хэмжээ нь 50 сая төгрөг байна.

3. Банк нь өөрийн болон бусад санг өөрийн ашиг, хөрөнгөөр байгуулж болно.

4. Сан байгуулах журмыг банк өөрөө тогтооно.

### 34 дугаар зүйл. Татвар төлөх

Банк нь БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу албан татвар төлнө.

### 35 дугаар зүйл. Банкны үйл ажиллагаанд тавих шаардлага

Банк үйл ажиллагаандаа дор дурдсан шаардлагыг хангаж ажиллана:

1) байгууллагда, иргэдэд гэрвэний үндсэн дээр зээл-тооцсоны болон банкны бусад ажил үйлчилгээг үзүүнэ;

2) бусдаас авсан хөрөнгийнхөө зохих хэсгийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанкнаас тогтоосон хэмжээгээр байлгана;

3) бусдаас авсан хөрөнгийн зохих хэсгийг Монголбанкны тогтоосон журмын дагуу даатгуулна;

4) харилцагчийн данс, хадгаламж, гүйлгээтэй холбогдох нууцыг чанд хадгална (харилцагч байгууллагын данс, хадгаламж, гүйлгээний талаар өөрийн эвшөөрснөөр буюу эсвэл гагцхүү шүүх, прокурор, мөрдөн байцаах байгууллагын хууль ёсны шаардлагын дагуу тодорхойлолт гарган өгч болно);

5) харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн бүтэн байлгаж, төдгөрийн анхны шаардлагаар гаргаж өгнө;

6) харилцагчийг хэд хэдэн банкээр үйлчлүүлэхэд хязгаарлалт тавихгүй байна;

7) банкны үйл ажиллагааны талаар дангаар ноёрхох, ашгаа нэмэгдүүлэхийн тулд холбоо, нийгэмлэгийг ашиглах, өвсөн нэгдэхийг хориглоно.

### 36 дугаар зүйл. Банк хоорондын гүйлгээ

1. Банк нь шаардагдах мөнгөн тэмдэгтийг захиалгын үндсэн дээр Монголбанкны дахь харилцах дансаараа дамжуулан авч мөн дансаар дамжуулан өргүүлж төлнө.

2. Банкууд өөр хоорондын гүйлгээг гэрвэний үндсэн дээр хийнэ.

3. Банкууд хоорондын тооцосгоо Монголбанкны дахь харилцах дансаар дамжуулан хийнэ.

### 37 дугаар зүйл. Хүү

Банкнаас олгох зээлийн болон бусдаас авах хөрөнгөнд төлөх хүүгийн хэмжээг банк өөрөө тогтооно.

*38 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж*

1. БНМАУ-ын болон гадаадын иргэд, харьяалаагүй хүмүүс мөнгөн хөрөнгөө аль ч банкинд хадгалуулах эрхтэй. Иргэд нь үйлчлүүлэх банкаа өөрөө сонгож, нэг буюу хэд хэдэн хадгаламжтай байж болох бөгөөд түүнийг захиран зарцуулах, хүү болон хадгаламжтай холбогдсон бусад орлого олох эрхтэй.

2. Хадгаламжаа өвлүүлэх талаар банкинд үүрэг дээдгээгүй, хууль ёсоор гэрээслээгүй бол уг хадгаламжийг өвлүүлэх асуудлыг БНМАУ-ын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

3. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр хадгаламжаас аливаа төлбөр гаргуулах буюу түүнийг дайчлан хураан авахыг хориглоно.

4. Хадгалуулагч нь хадгаламжтай холбогдсон гомдсоо шүүхэд гаргаж болно.

*39 дүгээр зүйл. Үнэт зүйлийн хадгалаат*

Банк нь иргэдийн үнэт зүйлийг (хадгалуулагчийн хувьд үнэт зүйл) хадгалах үйлчилгээг эрхэлж болох бөгөөд хадгалаатын гэрээний нөхцөлийг банк БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн тогтооно.

*40 дүгээр зүйл. Гадаад төлбөр тооцоо*

Банк гадаад төлбөр тооцооны болон бэлэн валютыг худалдан авах, худалдахтай холбогдсон ажлаа үйлчилгээг гэгцхүү Монголбанкны зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болно.

*41 дүгээр зүйл. Банкны тайлан тэнцэл, мэдээ*

Банк үйл ажиллагааныхаа үр дүнгийн тайлан тэнцлээ тогтоосон журмын дагуу Монголбанк, санхүүгийн байгууллаагад ярууланэ. Жилэйн тэнцэл, шинг, гадаадамы тайлангийн хураангуйг Монголбанкнаас батаасан маягтаар, тогтоосон хугацаанд хэвлэлд нийтлүүлэнэ.

*42 дугаар зүйл. Банкны үйл ажиллагааг зогсоох, татав буулгах*

1. Банкны үйл ажиллагааг дор дурдсан үндэслэлээр зогсооно:

1) дүрэмд заасан журмын дагуу банк үүсгэн байгуулагчдын шийдвэрээр;

2) энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу гаргасан Монголбанкны шийдлэрээр;

3) дампуурсан тухай эрх бүхий байгууллаагын зарласнаар;

4) хуульд заасан бусад үндэслэлээр.

2. Банкны үйл ажиллагааг зогсоосон тухай улсын бүртгэлийн байгууллаагаас нийтэд зарласнаар тухайн банкыг татан буугдсанд тооцно.

3. Татан буугдсан банкны эцсийн тооцоог БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу хийнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Хяналт, хариуцлага*

43 дугаар зүйл. Банкны хяналт

Арилжааны банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг Монголбанк энэ хуулийн хүрээнд хэрэгжүүлэнэ.

44 дүгээр зүйл. Банкны тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Банкны тухай хууль тогтоомж зөрчигчдөд БНМАУ-ын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

45 дугаар зүйл. Маргааныг хянан шийдвэрлэх

Арилжааны банкны талаар Монголбанкны гаргасан шийдвэр, түүнийг дагаж мөрдөхөөс үүдэн гарсан маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

46 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1991 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

БНМАУ-ын Бага Хуралын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хуралын  
парийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 4 дүгээр  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 4 дүгээр

Дугаар 13

Улаанбаатар

сарны 23-ны өдөр

207

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас батаасан БНМАУ-ын Тэтгэмжийн хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хуулийг тус тус зөвшөөрөн батламжиласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ТЭТГЭМЖИЙН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

*Нийтлэл үндэслэл*

*1 дүгээр зүйл.* БНМАУ-ын Тэтгэмжийн хуулийн зорилт  
БНМАУ-ын Тэтгэмжийн хуулийн зорилт нь иргэдэд тэтгэмж  
тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Тэтгэмжийн тухай хууль тогтоомж

Тэтгэмжийн тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй  
нийцүүлэн гаргасан БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад ак-  
таас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Тэтгэмжийн төрөл

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний  
болон амаржсаны, хүүхдийн, хүүхэд асарсны ажилгүйдлийн гэг-  
сэн үндсэн төрөлтэй байна.

*4 дугаар зүйл. Тэтгэмж авах эрх*

1. Дор дурдсан иргэд тэтгэмж авах эрхтэй:

1) улс, хоршоолоод, олон нийт, хувийн үйлдвэрийн газар, байгууллагын ажилтан, иргэд хоорондын гэрээгээр болон хуниараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэн;

2) зэвсэгт хүчин, улсын аюулгүй байлалыг хангах, цагдаагийн болон засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын генерал, офицер, улирсан албан хаагч, цагдаа, хянагч, гал сөнөөгч, төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалаагийн албан хаагч, иргэний агаарын тээврийн албан тушаалын зөргөлзөлтэй ажилтан;

3) БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа хамтын болон гадаадын үйлдвэрийн газар, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг БНМАУ-ын иргэн;

4) БНМАУ-ын аль нэгэн байгууллагад ажилладаг тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалаагүй хүмүүс;

5) энэ хуулийн дагуу тэтгэмж авах эрх бүхий бусад иргэн.

2. Иргэдийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж авах эрх нь улсын нийгмийн даатгалд даатгагдан шимтгэл төлсөн нөхцөлд үүснэ.

*5 дугаар зүйл. Тэтгэмжийг санхүүжүүлэх хөрөнгө*

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг БНМАУ-ын Тэтгэврийн сангаас, ажилгүйдлийн тэтгэмжийг тухайн иргэний ажиллаж байсан байгууллаагаас хөдөлмөрийн загалд төлсөн хураамжийн хөрөнгөөс хүүхдийн, хүүхэд асарсны тэтгэмжийг улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

*Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж*

*6 дугаар зүйл. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох нөхцөл*

Өвчилсөн, өсөлд өрсөн, хиймэл эрхтэн хийлгэсний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсан, гэр бүлийн гишүүнээ буюу хууль ёсны асрамжуулагчаа өвчлөхөд асран сахисан иргэнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгоно.

*7 дугаар зүйл. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа*

1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн чадвар нь сэргэх хүртэл, эсхүл тахир дутуугийн зэрэг тогтоох хүртэл хугацаанд ажлын өдрөөр тооцож олгоно.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хягаар нь сүрьеэгээр анх өвчлөхөд 12 сар, хорт хавдар, артаг сүрьеэгээр өвчлөхөд 6 сар, бусад өвчнөөр өвчлөхөд 3 сараас нэлүүгүй байна.

8 дугаар зүйл. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ

1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсан иргэнд сарын дундаж хөдөлмөрийн хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно.

2. Өвчтөн асран сахигчид сарын дундаж хөдөлмөрийн хөлстэй 50 хувьтай тэнцэх тэтгэмж олгоно.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт зааснаас бусад тохиолдлоор хөдөлмөрийн чадвар түр алдсан иргэнд сарын дундаж хөдөлмөрийн хөлстэй дор дурдсан хувьтай тэнцэх тэтгэмж олгоно:

Ажилласан хугацаа	Тэтгэмж бодох хувь	
	эмнэлэгт хэвтэж өмчлүүлэхэд	эмнэлэгт хэвтэхгүй өмчлүүлэхэд
6 хүртэл жил	45	60
6—13 жил	55	70
14 ба дээш жил	65	80

4. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасны дагуу олгосон тэтгэмжийг тухайн байгууллаагийн захиргаа БНМАУ-ын Тэтгэврийн санд нөхөн төлнө.

9 дүгээр зүйл. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохгүй тохиолдол

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг өөрийн эрүүл мэндэд санаатайгаар гэм хор учруулсан, хуурамчаар өвчилсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэсний уршгаар осолд орсон, өмчилгээнээс санаатайгаар зайлсхийсэн тохиолдолд олгохгүй.



## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Жирэмсний болон амаржсаны тэтгэмж*

*10 дугаар зүйл.* Жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох кугацаа

Эхчүүдэд хүүхэд төрүүлэхийн өмнө 45 (нэр бол 70) хоног, амаржсаны дараа 56 хоног, хүүхэд хүндрэлтэй төрүүлсэн, эсхүл ихэр хүүхэд төрүүлсэн бол 70 хоногийн амралтын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.

*11 дүгээр зүйл.* Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг сарын дундаж хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр ажлын өдрөөр тооцож олгоно.

*12 дугаар зүйл.* Хүүхэд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн эхчүүдэд тэтгэмж олгох

1. Хүүхдээ 196 хоногоос дээш тээгээд дутуу төрүүлсэн буюу эмнэлгийн дүгнэлтээр үр хөндүүлсэн, 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдэд амаржсаны тэтгэмж олгоно.

2. Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн эмэгтэйчүүдэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр тэтгэмж олгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Хүүхдийн тэтгэмж*

*13 дугаар зүйл.* Хүүхдийн тэтгэмжийн төрөл

Хүүхдийн тэтгэмж нь нярай хүүхдийн арчилгааны, олон хүүхэдтэйн, ихэр хүүхдийн гэсэн төрөлтэй байна.

*14 дүгээр зүйл.* Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж

Эцэг, эхийн сарын дундаж хөдөлмөрийн хөлсний нийлбэр 1200 төгрөг хүрэхгүй бол хүүхэд төрснөөс хойш 3 сарын дотор нярай хүүхдийн арчилгааны тэтгэмжид нэг удаа 440 төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн бол эцэг, эхийн хөдөлмөрийн хөлсний хэмжээг харгалзахгүйгээр хүүхэд бүрт 600 төгрөг олгоно.

*15 дугаар зүйл. Олон хүүхэдтэйгн тэтгэмж*

1. Төрүүсэн болон үрчлэн авсан арван зургаа хүртэл насны зэрэг ба түүнээс дээш хүүхэдтэй өх (тану бие эцэг)-д олон хүүхэдтэйгн тэтгэмжийг дэр дурдсан хэмжээгээр жилд нэг удаа олгоно:

Хүүхдийн нас	хүүхэд бүрт жилд олгох тэтгэмжийн хэмжээ (төгрөгөөр)
0—3	100
4—7	250
8—13	450

2. Хүүхдийн тоо, насны тухайн жилийн 1 дүгээр сарын нийг байдлаар тооцно.

*16 дугаар зүйл. Ихэр хүүхдийн тэтгэмж*

Ихэр хүүхэд тус бүрт 1000 төгрөгийн тэтгэмж нэг удаа олгоно.

*17 дугаар зүйл. Хүүхдийн тэтгэмж олгохгүй тохиолдол*

Хүүхдийг улсын зардлаар асарч байгаа бол энэ хуулийн 14, 5, 16 дугаар зүйлд заасан тэтгэмжийг давхардуулан олгохгүй.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Хүүхэд асарсны тэтгэмж

*18 дугаар зүйл. Хүүхэд асарсны тэтгэмж олгох нөхцөл*

1. Төрүүсэн буюу үрчлэн авсан хүүхдээ хоёр (ихэр бол арван) настай болтол нь асрахаар өөрийнхөө хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн эхэд амаржсаны болон өөлийн амралт дэлсний дараа хүүхэд асарсны тэтгэмж олгоно.

2. Төрүүсэн эх нь хүндэтгэх шалтгаанаар хүүхдээ асарч адалгүй болсон буюу нас барсан, түүнчлэн хүүхэд үрчлэн аван тохиолдолд энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан насны хүүхэд асрахаар ажлаас чөлөөлөгдсөн иргэнд хүүхэд асарсны тэтгэмж олгоно.

*19 дугаар зүйл. Хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээ*

Хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээ нь сард 240 төгрөг, хэр хүүхэдтэй бол сард 300 төгрөг байна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### *Ажилгүйдлийн тэтгэмж*

*20 дугаар зүйл. Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөл*

Хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөрлөхийг хүсч, ажил идэвхтэй эрж байгаа ажилгүй иргэнд дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгоно:

1) үйлдвэрийн газар, байгуулалга татан буугдсан, орон тоо нь хасагдсан, өсхүл ажилтны тоог цөөрүүлсэн, өөрөөс нь үл хамарах шалтгаанаар мэргэжил, чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсны улмаас ажлаас халагдсан;

2) ажлаас халагдсанаас хойш 10 хоногийн дотор хөдөлмөрийн захад бүртгүүлж, эрх бүхий байгууллаагаас зохион байгуулсан ажил хөдөлмөрт тогтмол оролцсон;

3) нийгмийн даатгалд даатгагдан 2-оос доошгүй жил ажилласан.

*21 дүгээр зүйл. Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа*

1. Ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаа нь ажлаас халагдсаны тэтгэмж авсан хугацаа дууссаны дараах өдрөөс эхэлнэ.

2. Ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас халагдсаны тэтгэмж авсан хугацааг оролцуулан 5 сар хүртэл хугацаанд олгоно.

*22 дугаар зүйл. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ*

Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

*23 дугаар зүйл. Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх хадгалагдах*

Ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэн хөдөлмөрийн захаас зуучилсан ажил гүйцэтгэж хөлс авсан бол тэтгэмжийг давхардуулан олгохгүй бөгөөд харин тэтгэмж авах хугацаа нь хадгалагдана.

*24 дүгээр зүйл. Ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох*

Ажилгүйдлийн тэтгэмжийг дор дурдсан тохиолдолд зогсооно:

1) тухайн иргэний мэргэжил, мэргэшлийг харгалзан хөдөлмөрийн захаас санал болгосон ажилд орохоос хүндэтгэх шалтгаангүйгээр татгалзсан;

2) эрх бүхий байгууллаагаас зохион байгуулсан ажил, хөдөлмөрт хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй;

3) ажилгүйдлийн тэтгэмжээс өөр орлогын эх үүсвэртэй болох нь тогтоогдсон.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### *Бусад явдал*

*25 дугаар зүйл.* Тэтгэмжийн хэмжээг өөрчлөх

Хүн амын амьжиргааны өртгийн хялбарзалттай уяадуулан тэтгэмжийн хэмжээг БНМАУ-ын Засгийн газар өөрчлөн тогтооно.

*26 дугаар зүйл.* Тэтгэмжийн хуулийг хэрэглэх журам

Энэ хуулийг хэрэглэх журмыг нийгэм хангамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

*27 дугаар зүйл.* Тэтгэмжтэй холбогдсон гомдол гаргах

Иргэд энэ хуульд заасан тэтгэмжтэй холбогдсон гомдлоо орон нутгийн нийгэм хангамжийн байгууллагад гаргаж болно. Орон нутгийн нийгэм хангамжийн байгууллагын шийдвэрийг зөвшөөрөхгүй бол гомдлоо нийгэм хангамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад буюу шүүхэд гаргана.

*28 дугаар зүйл.* Тэтгэмжийн хууль тогтоомжийн биелэвтэд хяналт тавих байгууллага

БНМАУ-ын Тэтгэмжийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэвтийг хянан шалгах үүргийг нийгэм хангамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн Ардын Хурал, тэдгээрийн гүйцэтгэх захиргаа эрхлэн гүйцэтгэнэ.

*29 дүгээр зүйл.* Тэтгэмжийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

Тэтгэмжийн хууль тогтоомж зөрчсөн буруутай этгээдэд БНМАУ-ын хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ХУУЛЬ**

1991 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр  
Улаанбаатар хот

**ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

**БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:**

БНМАУ-ын Тэтгэмжийн хууль батлагдсантай холбогдуулан «Олон хүүхэдтэй ээчүүдэд улсын тэтгэвэр олгох журамд зарим өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигийг баталсан БНМАУ-ын 1971 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

**Р. ГОНЧИНДОРЖ**

БНМАУ-ын Бага Хурлын  
шарийн бичгийн дарга

**Б. ЧИМИД**

БУГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЛЭЛЭГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 4 дүгээр  
сарны 26-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан «Үйлдвэрчний эвлалуудийн эрхийн тухай БНМАУ-ын хууль»-ийг зөвшөөрөн батламжласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН  
ТУХАЙ БНМАУ-ЫН ХУУЛЬ

*1 дүгээр зүйл. Хуулийн зорилт*

Энэ хуулийн зорилт нь иргэд хөдөлмөрлөх эрхээ хэргэжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор сайн дураараа чөлөөтэй эвлэдэн нэгдэж үнд ажилалгада явуулах эрхийг баталгаажуулж, энэ хүрээнд үүссэн нийгмийн хариуцааг зохицуулахад оршино.

*2 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай  
БНМАУ-ын хууль тогтоомж*

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль тогтоомж нь БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгэртэй нийцүүлэн гаргасан БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэл эвлэдэн нэгдэх эрх*

1. Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэргэжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр

ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.

2. Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр басгах буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй.

3. Үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн бие даасан байдлыг хангах

1. Үйлдвэрчний эвлэлүүд нь мөргөжил, үйлдвэрлэлийн шинжээр байгуулагдаж үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд бие даан чөлөөтэй явуулна.

2. Үйлдвэрчний эвлэлүүд төгш эрхтэй.

3. Үйлдвэрчний эвлэлүүд нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж холбоо байгуулах, олон улсын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдэлд гишүүнээр басгах эрхтэй.

4. Үйлдвэрчний эвлэлүүд болон тэдгээрийн холбоод хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

5 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн үндсэн эрх

1. Үйлдвэрчний эвлэлүүд нь хөдөлмөрийн харилцаатай холбогдсон үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан үндсэн эрх эдэлнэ:

1) захиргаа, эзэдтэй хэлэлцээ хийж хамтын болон бусад гэрээ байгуулах, түүнийг биелэлтэд хяналт тавих;

2) хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагад гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлөн хамгаалах;

3) хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон БНМАУ-ын хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, тэдгээрийг сэхин биелүүлэхийг захиргаанаас шаардах;

4) хөдөлмөрлөх эрхийг хохироосон захиргааны шийдвэрийг түдгэлзүүлэн зогсоохыг болон өөрчлөх, хүчингүй болгох, гэрээг цуцлахыг шаардах;

5) хөдөлмөрлөх эрхийг хамгаалахтай холбогдсон аливаа асуудлаар гишүүд, ажилтны санал бодол, эрэлт хэрэгцээг судлан захиргаанд шаардлага тавих, мэдэгдэл гаргах, зохих байгууллагад төлөөлөх;

6) гишүүд, ажилтныгаа зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоолгохоор шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;

д) хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон аливаа асуудлыг хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэхийг санал болгох буюу гишүүдээрээ бие даан хэлэлцүүлэг зохион байгуулах;

8) Үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай мэдээллийг захиргаанаас гаргуулан авах;

9) БНМАУ-ын хууль тогтоомжинд заасан журмаар жагсаал, цуглаан, ажил хаялт зохион байгуулах;

10) БНМАУ-ын хууль тогтоомжинд заасан бусад эрх.

2. Тухайн байгууллагад хоёр, түүнээс дээш үйлдвэрчний эвлэл байвал тэдгээр нь тохиролдож, хамтарсан төлөөлөгчид томноон захиргаа, нээдтэй хамтын нэг гэрээ байгуулна.

Бусад тохиолдолд хамтын гэрээг нийт ажилтны төлөөлөгчид захиргалтай байгуулаж болно.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсгийн заалтууд үйлдвэрчний эвлэлийн орон нутгийн болон улсын хэмжээний холбоодод нэг адил хамаарна. (Энэ тохиолдолд «захиргаа» гэдэгт БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирамжаах дээд, төв болон орон нутгийн байгууллагыг хамааруулан ойлгоно)

4. Үйлдвэрчний эвлэлүүдийн улсын хэмжээний нэгдсэн холбоо (хэд хэдэн холбоо байвал тэдгээрийн төлөөлөгчид) нь БНМАУ-ын Засгийн газар, эздийн улсын хэмжээний байгууллагатай нийгмийн зөвшилцлийг хангах гурван талт хялалцээр байгуулаж болно. Энэхүү хялалцээр байгуулах журмыг оролдогч талууд тогтооно.

*6 дугаар зүйл.* Үйлдвэрчний эвлэлүүдийн үйл ажиллагааны болон түүний сонгуульд ажилтны эрхийн баталгаа

1. Үйлдвэрчний эвлэлүүдийг захиргааны журмаар тараах, үйл ажиллагааг нь зогсоох, мөшгин хавчих зэргээр үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

2. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй үйлдвэрчний эвлэлийн сонгуульд ажилтныг өөрийн болон сонгосон хамт олох нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачлагаар ажлаас халах, түүнд сонгуульд үүрэгтэй нь холбогдуулан сахлагын шийтгэл оногдуулахыг хориглоно.

3. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн үйлдвэрчний эвлэлийн сонгуульд ажилтны сонгуулийн хугацаа дуусгавар болсон, түүнчлэн хүндэтгэн үзэх бусад шаалтгаанаар сонгуульд үүргээсээ чөлөөлөгдсөн тохиолдолд захиргаа түүнийг хуучин ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол өөрийн нь зөвшөөрснөөр урьд авч байсан дундаж хөлс нь буурахааргүйгээр ажил олгоно.

4. Үйлдвэрчний эвлэл, түүний сонгуульд ажилтныг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл, бололцоогоор хангах асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн үйлдвэрчний эвлэлийн сонгуульд ажилтанд хамтын гэрээ нийт ажилтны нэг адил хамаарна.



5. Үйлдвэрийн газар, байгууллагын захиргааны удирдах албан тушаалтан үйлдвэрчний эвлалын сонгуульд ажилт хэсгээр гүйцэтгэж болдоггүй.

7 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлалуудийн санхүү, эд хөрөнгө

1. Үйлдвэрчний эвлалууд нь өөрөө сансүүжих зарчмаар ашиглагддаг.

2. Үйлдвэрчний эвлалуудийн эд хөрөнгө нь гишүүдийн татвар, хэвлэл, үйл ажиллагаагаар явуулдаг шаардлага бусад эд хэсгээс бүрддэг.

8 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлалуудийн эрхийн тухай олон улсын гэрээг сахин битсгүүлэх

Үйлдвэрчний эвлалуудийн эрхийн тухай БНМАУ-ын хууль тогтоомжийн эсвэл БНМАУ-ын олон улсын гэрээний заалтын зөрчилдөөл уг олон улсын гэрээний заалтыг баримтална.

9 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлалуудийн эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөний зарцуулага

1. Үйлдвэрчний эвлалуудийн эрхийн тухай БНМАУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн гэм бүртгэж өгөхөд БНМАУ-ын хууль тогтоомжид заасан үндсээр, журмын дагуу зарцуулага

хувиарлагддаг.

2. Үйлдвэрчний эвлал БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуулийг зөрчөөл тийнхүү хууль зөрчсөн үйл ажиллагааг шүүхийн шийдвэрээр зогсоож болно.

10 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БНМАУ-ын Батл Хурал  
дэргэ

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Батл Хурал  
нэрхэн бичгийн дэргэ

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТААМЖ

1991 оны 5 дугаар

Дугаар 15

Улаанбаатар

сарны 7-ны өдөр

ХТҮ

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан «БНМАУ-ын Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль»-ийг зөвшөөрөн батламжласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## БНМАУ-ЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Нийгмийн даатгалын шимтгэл бол БНМАУ-ын Тэтгэврийн сангийн үндсэн эх үүсвэр мөн. Энэ хуулийн зорилт нь БНМАУ-ын Тэтгэврийн санд нийгмийн даатгалын шимтгэл төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль тогтоомж

БНМАУ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### 3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг

1. Иргэдийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байгаа дор дурдсан үйлдвэрийн газар, байгууллага, иргэд нийгмийн даатгалын шимтгэл заавал төлөх үүрэгтэй:

- 1) төрийн үйлдвэрийн газар;
- 2) улс, орон нутгийн төсвөөр санхүүждэг байгууллага;
- 3) олон нийтийн болон шашны байгууллага;
- 4) хоршоолол, хувийн үйлдвэрийн газар, пүүс;
- 5) БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хувь нийлүүссэн болон БНМАУ-ын хуулийн этгээдийн эрх бүхий гадаадын үйлдвэрийн газар, байгууллага;
- 6) БНМАУ-ын иргэдийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байгаа гадаадын байгууллага, иргэд, харьяалаагүй хүмүүс.

2. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэн өөрөө хүсвэл сайн дурын үндсэн дээр тогтоосон хувь, хэмжээгээр шимтгэл төлж улсын нийгмийн даатгалд хамаарагдаж болно.

### 4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх үндэслэл, журам

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан үйлдвэрийн газар, байгууллага, иргэд цалингийн буюу хөдөлмөрийн хөдсний сан, түүнтэй адилтгах бусад сангаас тогтоосон хувь, хэмжээгээр тооцож БНМАУ-ын Тэтгэврийн санд нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох, төлөх, тайлагнах журмыг БНМАУ-ын Тэтгэврийн сангийн дүрмээр тодорхойлно.

*5 дугаар зүйл.* Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

*6 дугаар зүйл.* Харнуцлага

Нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг бүхий этгээд энэ хуулийг зөрчвөл санхүүгийн болон нийгэм хангамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага дор дурдсан харнуцлага хүлээлгэнэ:

1) шимтгэл ногдуулах цалингийн болон хөдөлмөрийн хөлсний сангийн хэмжээг санаатайгаар бууруулж мэдээлсэн буюу нуун дарагдуулсан зэргээр хугацаанд нь төлөөгүй, өслүл дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлж гэм буруутай этгээдэд энэ зүйлийн 3-т заасан торгуулийг оногдуулна;

2) шимтгэлийг хугацаанд нь төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам төлвөл зохих шимтгэлийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх торгууль (алданги)-ийг төлүүнэ;

3) шимтгэлийг дутуу төлсөн, хугацаа хожимдуулсан, бүртгэл, тооцоог будиантуулсан гэм буруутай этгээдийг эрүүгийн харнуцлага хүлээлгэхээргүй байвал 100—1000 хүртэл төгрөгөөр торгоно.

*7 дугаар зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БНМАУ-ын Бага Хуралын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хуралын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 4 дүгээр  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын хууль тогтоомжийг 1991—1992 он, 1993 оны эхний хагаст боловсронгуй болгох төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БНМАУ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖИГИЙГ 1991—1992 ОН, 1993 ОНЫ ЭХНИЙТ ХАГАСТ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хууль тогтоомжийн түслийн нэр	Гүйцэтгэх байгуулалт		Засгийн газарт оруулах (ср, сар)	Улсын Бага Хурлын чуулга- ынгар хуралдаж (он, чуулганы дугаар)
	тоололох	хамтран оролцох		
1	2	3	4	5

### Нэг. Шинээр боловсруулах хууль тусгасны

1. Алх ахуйн үйл ажиллагааны хууль  
Хулалдаа, үйлдвэрийн  
нэм  
Хөдөлмөрийн яам,  
Сангийн яам, Үндэсний  
коопляцийн яам, Хууль  
зүйн яам  
1991 оны  
III  
1-р сар
2. Алх ахуйн дампууралын  
тухай хууль  
Сангийн яам  
Хулалдаа, үйлдвэрийн  
нэм  
— —
3. Өмч хувьцаалын тухай  
хууль  
Төсөл боловсруулах  
хэлтэс  
1991 оны  
4-р сар
4. Шударга өрсөлдөөний-  
дэвхлэх, дансаар нэрлэх-  
хэг хянаргаарлах тухай  
хууль  
Хууль зүйн яам  
Хөдөлмөрийн яам,  
Хулалдаа, үйлдвэрийн  
нэм  
1991 оны  
III  
2-р сар
5. Газрын тухай хууль  
Бийгаль орчин хөгжлө-  
хтэй улсын хэрэг  
Хөдөлгөөн зүйн яам,  
Шинжлэх ухааны ака-  
деми, Хууль зүйн яам,  
Үндэсний төгсгөлийн яам  
1991 оны  
III  
2-р сар
6. Үнэт цаасны тухай хууль  
Улсын банкны ерөнхий  
хэрэг  
Сангийн яам, Хулалдаа,  
үйлдвэрийн яам  
1991 оны  
IV  
7-р сар

0	1	2	3	4	5
7. Актим хууль	Уасмын банкны ерөнхий хороо	Сангийн нам, Байгаль орчны аялалтын Уасмын хороо	1991 оны 7-р сар	1991 IV	
8. Патентын тухай хууль	Үндэсний хөгжлийн нам	Шинжлэх ухааны академи, Соёл, урлагийн хөгжлийн хороо, Хууль зүйн нам	1991 оны 2-р сар	1991 III	
9. Банкны тухай хууль	Уасмын банкны ерөнхий хороо	Сангийн нам	1991 оны 1-р сар	1991 III	
10. Хөвсгөн нийтлэх эрх чөлөө, явдал нэгдлийн газруудын тухай хууль	Хууль зүйн нам	Сангийн нам	1991 оны 2-р сар	1991 III	
11. Зорчих, цагцамак тухай хууль	Галаад зорицалын нам	Хууль зүйн нам, Цагдаагийн Ерөнхий газар	1991 оны 2-р сар	1991 III	
12. Үйлдвэртний өмчлөлийн тухай хууль	Уасмын Бага Хурлын гишүүн С. Чулуун-баатар	Хууль зүйн нам	1991 оны 1-р сар	1991 III	
13. Төрийн ордны тухай тогтоол	Хууль зүйн нам	Сангийн нам	1991 оны 3-р сар	1991 III	
14. Харюулагчийн эрхийг хамгаалах тухай хууль	Худалдаа, үйлдвэрийн нам	Хууль зүйн яам, Үндэсний хөгжлийн нам	1991 оны 4-р сар	1991 III	
15. Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хууль	Тусгай боловсруулах комисс	Хууль зүйн нам	1991 оны 8-р сар	1991 IV	
16. Мал эмгэлэг, үржлийн хууль	Хөдөө аж ахуйн нам	Үндэсний хөгжлийн нам	1991 оны 7-р сар	1991 IV	
17. Ургамлын хорноо цээр, үрлийн аж ахуйн тухай хууль	Хөдөө аж ахуйн нам	Зуура мэндийн нам, Уасмын хяналт байцаах газар	1991 оны 7-р сар	1991 IV	
18. Өнгөөллийн тухай хууль	Хууль зүйн нам	Уасмын дээд шүүх, Уасмын прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар	1991 оны 7-р сар	1991 IV	

0	1	2	3	4	6
19.	Төрийн албам тухай хууль	Хууль зүйн яам	Хөдөлмөрийн яам	1991 оны 8-р сар	1991 IV
20.	Үнэ, үнэ бүрэлдлийн тухай хууль	Худалдаа, үйлдвэрийн яам	Үндэсний хөгжлийн яам, Сангийн яам, Хөдөө аж ахуйн яам	1992 оны 1-р сар	1992 VI
21.	Үндэсний стандартчлалын хууль	Үндэсний хөгжлийн яам	Худалдаа, үйлдвэрийн яам, Улсын хэвнэ бай. цах газар	1992 оны 3-р сар	1992 VI
22.	Валютын тухай хууль	Сангийн яам	Улсын банкны ерөнхий хороо, Хууль зүйн яам, Галдад харилцааны яам	1991 оны 4-р сар	1991 IV
23.	Эрчим хүчний хууль	Эрчим хүчний яам	Улсын хэвнэ байдлаа газар	1992 оны 4-р сар	1992 VI
24.	Зохлогчийн эрхийн тухай хууль	Хууль зүйн яам	Үндэсний хөгжлийн яам, Шинжлэх ухааны яам, Соёл, урлаг, гүйв хөгжлийн хороо	1991 оны 2-р сар	1991 III
25.	Тэтгэмжийн хууль	Хөдөлмөрийн яам	Хууль зүйн яам	1991 оны 1-р сар	1991 III
26.	Мэдээллийн хууль	Үндэсний хөгжлийн яам	Хууль зүйн яам	1992 оны 6-р сар	1992 VI
27.	Тамхитай тэмцэх хууль	Эрүү мандийн яам	Худалдаа, үйлдвэрийн яам	1991 оны 3-р сар	1991 IV
28.	Байгаль орчны тухай хууль	Байгаль орчны хяналтын улсын хороо	Шинжлэх ухааны яам, «Ой, ан» институт, Хөдөө аж ахуйн яам, Эрүү мандийн яам, Хууль зүйн яам	1991 оны 9-р сар	1991 IV
29.	Ардгийн хууль	Хууль зүйн яам	Улсын аюулгүй байдал хэргийн ерөнхий газар, Соёл, урлагийн хөгжлийн хороо, Шинжлэх ухааны яам	1991 оны 10-р сар	1992 V



0 | 1 | 2 | 3 | 4 | 6

30. Олон нийтийн байгуулагын тухай хууль	Хууль зүйн нэм	Шинжлэх ухааны академи	1991 оны 1-р сар	1991 оны III
31. Хуулийн тусгай боловсруулалт, эрд нийтээр хэрэглэх тухай хууль	Хууль зүйн нэм	Шинжлэх ухааны академи	1992 оны 2-р сар	1993 VII
32. Ада нийтийн санал зурвалж оруулах тухай хууль	Хууль зүйн нэм	Шинжлэх ухааны академи	1992 оны 6-р сар	1993 VII
33. Уулсын хуулийн хяналтын тухай хууль	---	---	1991 12-р сар	1992 V
34. Онц байдла тогтоох тухай хууль	Цагдаагийн ерөнхий газар	Улсын аюулгүй байдлыг хамгаалах ерөнхий газар, Хууль зүйн нэм, Зүүн монголын нам	1992 оны 1-р сар	1992 V
35. Баталж зарлахаа тухай хууль	Баталж зарлахаа нам	Гадаад харилцааны нам	1991 оны 7-р сар	1991 IV
36. Улсын аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль	Улсын аюулгүй байдлыг хамгаалах ерөнхий газар	Цагдаагийн ерөнхий газар, Гадаад харилцааны нам	1991 оны 8-р сар	1991 IV
37. Захиргааны хэрэгслэлтний тухай хууль	Хууль зүйн нэм	Улсын дээд шүүх, Улсын прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Байгаль орчмыг хамгаалж улсын зорилго, Улсын хяналт байрлах газар	1991 оны 3-р сар	1991 IV
<b>Х.Сэр, Шинжлэх ухаан үзэсгэлэм</b>				
38. БНМАУ-ын хууль	Улсын комисс	Тусгай бэлтгэгчүүд		1991 III
39. Тэмдгийн хэрэглээний тухай хууль	Саягийн нэм	Гадаад харилцааны нам, Цагдаагийн ерөнхий газар	1991 оны 2-р сар	1991 IV

0	1	2	3	4	5
40.	Төсвийн эрхийн тухай хууль	Саягчийн яам	Улсын банкны ерөнхий хороо	1991 оны 9-р сар	1992 V
41.	Гадна оронтой харилцааны тухай хууль	Худалдаа, үйлдвэрийн яам	Сангийн яам, Улсын банкны ерөнхий хороо	1992 оны 3-р сар	1992 VI
42.	Хөдөлмөр хийгчдийн тухай хууль	Үндэсний хөгжлийн яам	Хууль зүйн яам	1991 оны 5-р сар	1991 IV
43.	Хамтын хөдөлмөрийн хөдөлгөөний тухай хууль	Хөдөлмөрийн яам	— " —	1991 оны 7-р сар	1991 IV
44.	Боловсролын хууль	Боловсролын яам	Шинжлэх ухааны академи, Үндэсний хөгжлийн яам, Соёл, урлагийн ажлын хороо	1991 оны 2-р сар	1991 III
45.	Сонгуулийн хууль	Хууль зүйн яам	Шинжлэх ухааны академи	1992 оны 9-р сар	1992 VI
46.	Депутатын хууль	Хууль зүйн яам	Шинжлэх ухааны академи	1992 оны 6-р сар	1992 VI
47.	БНМАУ-ын олон улсын гэрээ байгуулах, биелүүлэх, цуцлах журмын тухай хууль	Гадаад харилцааны яам	Худалдаа, үйлдвэрийн яам, Хууль зүйн яам	1991 оны 9-р сар	1992 V
48.	БНМАУ-ын хөрөнгийн хууль	— " —	Хууль зүйн яам	1992 оны 6-р сар	1993 VII
49.	БНМАУ-д байгаа гадаадын иргэдийн эрх, үүргийн тухай хууль	Гадаад харилцааны яам	Хууль зүйн яам	1992 оны 2-р сар	1993 VII
50.	Яаргал, цуглалын тухай хууль	Хууль зүйн яам	Цагдаагийн ерөнхий газар, Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар	1991 оны 11-р сар	1992 V
51.	Иргэний хамгаалалтын хууль	Баталн хамгаалах яам	Байгаль орчны хамгаалалтын улсын хороо	1992 оны 5-р сар	1992 VI
52.	БНМАУ-ын хэвлэлийн тухай хууль	Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар	Гадаад харилцааны яам	1991 оны 6-р сар	1991 IV

0	1	2	3	4	5
53.	Цагдаагийн байгуулалтын эрх, үүргийн тухай хууль	Цагдаагийн ерөнхий газар	Улсын прокурорын газар	1991 оны 8-р сар	1991 IV
54.	Эрүүгийн хууль	Хууль зүйн яам	Улсын дээд шүүх, Улсын прокурорын газар, Улсын амьтатгүй байдлаар хянтах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар	1991 оны 3-р сар	1991 IV
55.	Эрүүгийн байдал шийтгэх хууль	— <sup>o</sup> —	— <sup>o</sup> —	1991 оны 5-р сар	1991 IV
56.	Эрүүгийн ял өдлүүлэх тухай хууль	— <sup>o</sup> —	Улсын дээд шүүх, Улсын прокурорын газар	1991 оны 6-р сар	1991 IV
57.	Иргэний хууль	Улсын дээд шүүх	Улсын прокурорын газар, Хууль зүйн яам, Шинжлэх ухааны академи, Худалдаа үйлдвэрлэлийн яам	1991 оны 7-р сар	1991 IV
58.	Иргэний байрлал шийтгэх хууль	Улсын дээд шүүх	Улсын дээд шүүх, Улсын прокурорын газар, Хууль зүйн яам, Худалдаа, үйлдвэрлэлийн яам	1991 оны 7-р сар	1991 IV
59.	Прокурорын хяналтын хууль	Улсын прокурорын газар	Улсын дээд шүүх, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар	1991 оны 8-р сар	1991 IV
60.	Гэр бүлийн хууль	Хууль зүйн яам	Улсын дээд шүүх	1992 оны 4-р сар	1992 VI
61.	Нотариатын хууль	— <sup>o</sup> —	— <sup>o</sup> —	1991 оны 4-р сар	1992 V
62.	Эрүүл мэндийн хууль	Эрүүл мэндийн яам	Байгаль орчин хяналтын улсын хороо, Хөдөө аж ахуйн яам, Улсын янган байцаах газар	1991 оны 10-р сар	1992 VI

0	1	2	3	4	5
63.	Шашин шүтээлийн тухай хууль	Хууль зүйн яам	Шашин асуудал эрхлэх зөвлөл, Соёл, урлагийн хөгжлийн хороо	1991 оны 3-р сар	1991 III
64.	Аймаг, хотын Хурлын хууль	Төсөл боловсруулах эрхлэх	Хууль зүйн яам	1991 оны 3-р сар	1991 III
65.	Сум, хороо, район, орон нутгийн хотын Хурлын хууль	Төсөл боловсруулах эрхлэх	Хууль зүйн яам	1991 оны 3-р сар	1991 III
66.	Улсын үйлдвэрийн газрын тухай хууль	Үндэсний догмалын яам	Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яам, Сэлэнгийн яам	1991 оны 8-р сар	1991 IV
67.	Хоршооллын хууль	Худалдам, үйлдвэрийн яам	Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яам, Үндэсний догмалын яам	1991 оны 8-р сар	1991 IV

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 3 дугаар

Дугаар 17

Улаанбаатар

сарын 12-ны өдөр

хот

ЗАРИМ ХҮНИЙГ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Улсын Бага Хурлын байнгын хорооны дүрмийг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Бага Хурлын гишүүн Д. Лүндэвжанцан,  
Ц. Элбэгдорж, Ж. Бямбажав, О. Очиржав, Д. Батсүх нарыг  
Улсын Бага Хурлын байнгын хорооны нарийн бичгийн даргын  
сонгууль ажлаас 1991 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн чөлөөл-  
сүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 3 дугаар

Дугаар 18

Улаанбаатар

сарын 19-ний өдөр

хот

ЗАРИМ ХҮНИЙГ АЖЛААС ЧӨЛӨӨЛСӨНД  
ТООЦОХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын хянан шалгах хороо татан буугдсантай  
холбогдуулан ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын хянан шалгах хороо татан буугдаж  
түүний ажлааг цэгцлэн хуваагаж өгсөн тул Д. Даваацэрэнг

тус хорооны даргын үүрэгт ажлаас 1991 оны 1 дүгээр сарын 31-нээс, Ө. Ганхуягийн нэгдүгээр орлогч даргын үүрэгт ажлаас 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс, С. Банзрагчийг орлогч даргын үүрэгт ажлаас 1991 оны 2 дугаар сарын 28-нээс тус тус чөлөөсөнд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дэргэ

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

### БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 3 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ БНМАУ-ЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТУХАЙ

Зөрчих, цагаачлах тухай БНМАУ-ын хуулийн төсөлд өмнөх чуулганаар хявацж явцад гарсан гишүүдийн санааг бүрэн тусгажгүй, хэлбэгдэх тооцоо судалгаа хангалтгүй шийдсэн, төсвийн зөрчлийн ойлголтууд хоорондоо зөрөлтэй байгаа тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Зөрчих, цагаачлах тухай БНМАУ-ын хуулийн төслийг дахин сайтар боловсруулахаар БНМАУ-ын Засгийн газарт буцаасугай.

2. Зөрчих, цагаачлах тухай БНМАУ-ын хуулийн төслийг дахин боловсруулахдаа дараах асуудлыг тодруулах буюу нэмж тусгахыг Засгийн газарт даалгасугай:

а) хуулийн үндсэн нэр томъёоны тухай заалтыг төсөлд тусгаж, үндэслэлийг нь тайлбарлах; зөрчих, цагаачлах, дүрвэх, орогнох эрхийн ялгааг заагийг тодруулах;

б) гадаадын цагаач иргэдийг хүлээн авах, тэдний хөдөлмөр, ахуйн нөхцөлийг зохин байгуулах хууль зүйн үндсийг тогтоох;

в) уг хуулийг батлан мөрдөхөөс үүдэн гарах нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн үр дагаврын тооцоо судалгаа, дүгнэлтийг гаргаж танилцуулах;

г) дүрвэгсдийн эрхийн тухай олон улсын конвенц, протоколуудыг судлан, тэдгээрт БНМАУ нэгдэн орох боломжийн тухай асуудлыг боловсруулж БНМАУ-ын Бага Хуралд оруулах;

д) хуулийг дөрвөгжүүлэх журмыг боловсруулан хуулийн төсөлтэй хамт БНМАУ-ын Бага Хурлын чуулганд оруулах.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 3 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

### ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ БНМАУ-ЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газраас өргөн барьсан «Олон нийтийн байгууллагын тухай БНМАУ-ын хууль»-ийн төслийн таллаларх Эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын асуудлын болон Төрийн байгуулалтын байнгын хорооны хийсэн дүгнэлтийг сэнсээд Улсын Бага Хурлын гишүүдийн гаргасан санааыг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Энэхүү хуулийн төсөлд олон нийтийн байгууллага, тэдгээрийн төрөл зүйлийн тухай тулгуур ойлголт тодорхойгүй, зохицуулах гол гол асуудлын хүрээг бүрэн хамраагүйг болон манай орны улс төр, эдийн засгийн амьдралын өнөөгийн нөхцөл боломжийг зөв харгалзан гүйцэд боловсруулах шаардлагатайг үндэслэн «Олон нийтийн байгууллагын тухай БНМАУ-ын

хууль-ийн төслийг БНМАУ-ын Засгийн газарт буцаах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Уг хуулийн төслийг хянан хэлэлцэх явцад Улсын Бага Хурлын Байнгын хороодын хийсэн дүгнэлт, гишүүдийн гаргасан саналыг харгалзан дахин боловсруулж Улсын Бага Хуралд өргөн барихыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 4 дүгээр

Дугаар 23

Улаанбаатар

сарын 5-ны өдөр

хот

## БНМАУ-ЫН БАНКНЫ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Банкны хууль батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг түүнд нийцүүлэх арга хэмжээ алахыг БНМАУ-ын Засгийн газарт, Монголбанкны дүрмийн төсөл, дүрмийн сан, 1990 оны нэгдсэн тайлан тэнцэл, 1991 оны ашгийн хуваарилалт, орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулж 1991 оны 5 дугаар сарын 1-ний дотор БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлэхийг Монголбанкинд тус тус даалгасугай.

2. БНМАУ-ын Банкны хууль гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн «Гадаад валют болон түүгээр нлэрхийлсэн төлбөрийн баримтаар хууль бус гүйлгээ хийсэн хүмүүст хариуцаага хүлээлгэх тухай» 1986 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 46 дугаар зарлиг, «Валютын үнэт зүйлээр БНМАУ-ын нутаг дэвсгэрт хэлцэл хийх журмын



тухай» 1986 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 47 дугаар зарлыг 1991 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
сарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 4 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
 хот

## БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛААГААНЫ ТУХАЙ

«БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагаа, үр дүн, цаашдын зорилтын тухай» Засгийн газрын Ерөнхий сайд Д. Бямбасүрэнгийн хэвлэлийг сонсож хэлэлцээд БНМАУ-ын Бага Хурлаас ТЭМДЭГЛЭХ нь:

БНМАУ-ын Засгийн газар өнгөрсөн хугацаанд улс орны амьдралд тохиолдож байгаа бэрхшээлийг даван туулах талаар багагүй чармайлт гарган ажиллажээ. Гэвч улс орны өдийн засгийн хямрал гүнзгийрч, байдал ихээхэн хүндэрч байна. Олонхи үйлдвэр, аж ахуйн газарт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ажил үйлчилгээ, үр ашгийн үзүүлэлтүүд үлэмж хэмжээгээр буурлаа. Эдийн засгийн гадаад харилцаа өрөөсгөл хандлагатай хэвээр байгаагаас үйлдвэр, аж ахуйн газар гадаад материал, түүхий эдээр гачигдаж, үйлдвэрлэл нь доголдонг нэлээд нь сул зогсоход хүрч байна. Улсын санхүү төлбөрийн чадвар доройтож хүн амын нийгмийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд ноцтой бэрхшээл учирч, хот, хөдөөгийн хөдөөмөрчдийн соёл гэгээрэл, эмчлэлэг, холбоо, шуудан тээврийн үйлчилгээ олон талаар тасаалдаж байна. Үйлдвэрлэл, хөдөөмөрийн зохион байгуулалт, сахлага, дэг журам суларч улсын даалгаврыг тасаадуулах, түүнийхээ төлөө зарцуулага хүлээхгүй байх, төр, засгийн газарт болол-

цооноос хэтэрсэн шаардлага тулгах явдал цөөнгүй гарч байна. Ийм нөхцөлд Засгийн газар бодитой дүгнэлт хийх, цэгцтэй бодлого боловсруулан шийдвэртэй арга хэмжээ авч, шуурхай ажиглах боломжоогоо бүрэн ашиглахгүй байгааг анхааруулж байна. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааг эрчимжүүлэх, гишүүн бүрийнхээ хариуцлагыг эрс өндөржүүлэх шаардлагатай байна.

### **БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:**

1. БНМАУ-ын Засгийн газар (н. Бямбасүрэн)-т даалгах нь:  
а) аж ахуйг өмчлөх, өмч хувьчлах, дотоод нөөц боловцоог дайчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, валютын курс, үнийг төвлөрсөн байдлаар тогтоодог журмыг өөрчлөх, орон нутгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах зэрэг чиглэлээр тодорхой арга хэмжээг боловсруулж, энэ оны эхний хагас жилд багтаан хэрэгжүүлж эхэлсүгэй;

б) Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах талаар тавьсан саналынхаа үндэслэлийг Улсын Бага Хурлын гишүүдийн санал шүүмжлэлийг харгалзан боловсруулж, ойрын үед танилцуулахыг даалгасугай.

в) хүн амын ахуй, соёл гэгээрэл, шуудан холбоо, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах талаар орон нутгийн хөдөлмөрчдөөс Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүдээр уламжлан тавьсан шийдвэрлэгдээгүй асуудлуудыг судалж, холбогдох арга хэмжээ авч энэ оны 6 дугаар сарын 1-ний дотор Улсын Бага Хуралд танилцуулсугай;

г) хэврийн тариалалтын өмнө төв, суурин газрын иргэдээс хувиараа аж ахуй эрхэлж, хүнсний хэрэгцээгээ хангах боловцоог бүрдүүлэх зорилгоор эдэлбэр газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, үрээр хангах зэрэг шаардлагатай арга хэмжээ авсугай;

д) худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний цэг, салбаруудыг худалдах замаар хувьчлах шуурхай арга хэмжээ авсугай;

е) ирэх жилийн өвөдшилтийн бэлтгэлийг эртэй хангахад төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын хүчнийг дайчнаж, тодорхой үе шаттай ажла зохион байгуулсугай.

2. Хуулийн төсөл боловсруулах ажлын чанар, шуурхай байдлыг эрс дээшлүүлж, хуулийн биелэлтийг зохион байгуулах, хууль зөрчих явдалтай тэмцэх талаар харилцан ажиллагаагаа ндэрхжүүлэн сайжруулахыг Засгийн газар, хууль хамгаалах төв байгууллагуудад даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 4 дүгээр

Дугаар 25

Улаанбаатар

сарын 15-ны өдөр

ХОТ

**КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:**

«Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх доод нас, гэрлэлтийг бүртгэх тухай» Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1962 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн конвенцид БНМАУ нэгдэн орсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

**Р. ГОНЧИГДОРЖ**

БНМАУ-ын Бага Хурлын  
сарийн бичгийн дарга

**Б. ЧИМИД**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 4 дүгээр

Дугаар 26

Улаанбаатар

сарын 15-ны өдөр

ХОТ

**БНМАУ-ЫН ТЭТГЭМЖИЙН ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:**

1. БНМАУ-ын Тэтгэмжийн хуулийн 13, 14, 15, 16, 17 дугаар зүйлийг 1992 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, бусад зүйл, заалтыг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ онд олгогдоогүй байгаа олон хүүхэдтэй эхчүүдийн тэтгэврийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 140 дүгээр зарлигт заасан нөхцөл журмын дагуу 1991 онд олгож дуусгахаар тогтоосугай.

3. Гурав, түүнээс дээш ихэр хүүхдийг 4 нас хүртэл нь улсын зардлаар асрамжлан өсгөж байхаар зохих журам, зардлын хэмжээг тогтоож мөрдүүлэхийг БНМАУ-ын Засгийн газарт зөвшөөрсүгэй.

4. Тэтгэмжийн талаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, яам, улсын хороо, тусгай газраас урьд гаргасан шийдвэрүүдийг БНМАУ-ын Тэтгэмжийн хуульд нийцүүлэх арга хэмжээг авалтыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

5. «Олон хүүхэдтэй эхчүүдэд улсын тэтгэвэр олгох журамд зарим өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 140 дүгээр зарлигийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлийг 1992 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 4 дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар  
хот

### КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, МАХН-ын Төв Хорооны дарга Б. Даш-Ендонг БНМАУ-ын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын гишүүнээр баталсугай.

2. Г. Очирбатыг тус комиссын гишүүнээс чөлөөлсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1991 оны 4 дүгээр

Улаанбаатар

сарын 19-ний өдөр

Дугаар 28

хот

ХУУЛЬ БАТААГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН  
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль  
батаагдсантай холбогдуулан БНМАУ-ын Бага Хуралас ТОГ-  
ТООХ нь:

1. 1991 оны 6 дугаар сарын 1-ний дотор дор дурдсан арга  
хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай:

а) БНМАУ-ын хууль тогтоомж, Засгийн газрын бусад  
шийдвэрийг Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай  
БНМАУ-ын хуульд нийцүүлэх;

б) Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх журмын ту-  
хай хуулийн төслийг БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлэх.

2. Үйлдвэрчний эвлэлийн хорооны эрхийн дүрмийг батлах  
тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Төргүүлэгчдийн 1974  
оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 191 дүгээр зарлигийг 1991  
оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооц-  
сугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Б. ЧИМЭД

**БҮГД НАПРАМЛАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАМН ТОГТООА**

1991 оны 4 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

**ЦАЛИН, ХАНГАМЖИГН ТУХАЙ**

БНМАУ-ын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэснээс БНМАУ-ын Бага Хуралас **ТОГТГОХ** нь:

1. БНМАУ-ын Засгийн газрын тэргүүн шадар сайдын сарын цалиныг 4200 төгрөг, шадар сайдын сарын цалиныг 4000 төгрөг, Засгийн газрын бусад гишүүнш (сайдын) сарын цалиныг 3000 төгрөгээр тус тус тогтоосугай.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас бусад төрийн дээд, тэн байгууллагын удирдах ажилтанд тэдний өөрсөн сууц, гэрээ, түүш, усны үнэ хөлсөнд зарцуулж байсан тэнцвэр хангамжийг 1991 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбоотуулан төрийн тэн, орон нутгийн байгууллагуудын бусад удирдах аалбан тушаалтанд олгодог (холбооны хэрэгсэлнээс зардалас бусад) нөмгөн хангамж, хөнгөлөлттэй холбоотой нэмэгдлийг 1991 оны 6 дугаар сарын 1-ний өдөр тогтоох нэгдсэн эргэ хянгээ явцыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хуралын  
Арга

**Р. ГОНЧИГДОРЖ**

БНМАУ-ын Бага Хуралын  
Н.р-ийн бичгийн арга

**Б. ЧИМИД**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар  
хот

**ЛХАМЫН ЦЭРЭНДОНДОГИЙГ ЭЛЧИН САЙДЫН  
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Лхамын Цэрэндондогийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа. Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар  
хот

**ГОМБОСҮРЭНГИЙН ДАШДАВААГ ЭЛЧИН  
САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ**

Гомбосүрэнгийн Дашдавааг Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух. Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томиласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар  
хот

**НӨХӨР ПЭРЭНЛЭЙН ҮРЖИНАХҮНДЭВИЙГ  
ЭЛЧИН САЙДААР ТОХООН ТОМИЛОХ ТУХАЙ**

Пэрэнлэйн Үржинахүндэвийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсвас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар тохоон томилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 3 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

**Н. ДУЛМААД БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН  
БААТАР ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Үйлдвэрийн олон дамжлагыг эзэмшин үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн гарамгай амжилт гаргаж байгааг үнэлж, Цэргийн ёдлын үйлдвэрийн оёдолчин Надмидын **ДУЛМААД БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР** цол олгож, **СҮХ-ЛААТАРЫН** одон, «**АЛТАН СОЕМБО**» тэмдгээр шагнаусугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**



**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛЭГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 3 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

**НӨХӨР Ч. БАЛДАРТ БНМАУ-ЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ  
ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Эмнэлгийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, эмчилгээ, оношлогооны ажилд тэртүүн туршлага нэвтрүүлж асарын багачаар хийх мэс заслыг манай улсад анх хэрэгжүүлэн, хүн ардын эрүү мэндийг хамгаалахад өндөр амжилт гаргаж байгааг үнэлж, Армийн елэнхийн төв эмнэлгийн мэс заслын зөвлөх их эмч Чогсомын БАЛДАРТ БНМАУ-ЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ цол олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛЭГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 3 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
хот

**ЗАРИМ ХҮМҮҮСТ БНМАУ-ЫН ГАВЬЯАТ  
БАРИАГАЧИН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Бариагын цэргийн байгууллагад олон жил ажиллаж, үр бүтээлтэй ажиллаж улс ардын аж ахуй, соёл, үйлчилгээний олон арван бариагыг барьж ашигвэлтөд өгөхөд тодорхой хуви нэмэр оруулж хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байгааг үнэлж дор дурдсан хүмүүст БНМАУ-ЫН ГАВЬЯАТ БАРИАГАЧИН цол олгосугай:

1. Бадарчийн ШАРАВ — Бариагын дэргийн 017 дугаар ангийн сантехникчийн слесарьч, ахлагч
2. Гэдэгжамцын СЭР-ОД — Бариагын дэргийн 187 дугаар ангийн засаа чимэглэгч, ахлагч

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

991 оны 3 дугаар  
арын 16-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
ХОТ

**Ч. САНДРТ ХОШУУЧ ГЕНЕРАЛ ЦОЛ  
ОЛГОХ ТУХАЙ**

Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд Хилийн дэргийн дарга хурандаа Чегийн Сандрт ошууч генерал цол олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 3 дугаар

Дугаар 55

Улаанбаатар

сарын 18-ны өдөр

хот

**ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮРМИЙГ  
БАТЛАХ ТУХАЙ**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

БНМАУ-ын Ерөнхийлөгчийг 1991 оны  
зарлигаар батлав.

**ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮРЭМ**

*Нэг. Нийтлэл үндэслэл*

1. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь 1930—1950-иад оны эхэн үе, 1960-аад оны үед улс төрийн хилс хэрэгт татагдаж хэлмэгдсэн хүмүүсийн асуудлыг үргэлжлүүлэн судалж цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах төр, засгийн байгууллага мөн.

2. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын зорилт нь улс төрийн хэрэгт татагдаж шийтгэгдсэн хүний хэргийг шалгаж шийдвэрлүүлэх, цагаатгагдсан хүн, түүний гэр бүлийнхэнд тэтгэвэр, тэтгэмж олгуулах, хэлмэгдэгсдийн талаар судалж түүхэн үнэнийг тогтоох, нэр төрийг сэргээх ажилд холбогдох байгууллага, хүмүүсийг өргөн оролцуулах ажлыг зохион байгуулахад оршино.

3. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1990 оны 56, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 69, 1990 оны 119, 191 дүгээр зарлыг, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 69 дүгээр тогтоол болон БНМАУ-ын бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Тус комисс нь 1960-аад оны үед намын эсрэг бүлэг гэгчид холбогдон улс төрийн хэрэгт хилсээр хэлмэгдсэн хүмүүсийн асуудлыг МАХН-ын зохих байгуулалтын шийдвэр гарсны дараа авч үзэж байна.

5. Комисс үйл ажиллагаагаа ивуулахдаа тухайн асуудалтай холбогдоо бүхий олон нийтийн байгуулалтын санал, дүгнэлтийг харгалзаж байна.

6. Комисс эрх хэмжээнийхээ асуудлаар БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол гаргаж, биелэлтийг нь хангуулна.

7. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь тогтоогдсон журмаар хийсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

*Хоёр. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах  
Улсын комиссын үүрэг, эрх*

8. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) улс төрийн хэрэгт шийтгэгдэгсдийн хэргийг шалгаж шийдвэрлэх талаар Засгийн газрын дэргэдэх Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар, Улсын прокурорын газар, Улсын дээд шүүхээс хийж байгаа ажлатай тогтмол танилцаж байх;

б) цагаатгагдсан хүмүүсийн намтар түүх, нийгэм, улс төрийн үйл ажиллагааг судлах, нэр төрийг сэргээх ажлыг тэдгээр хүмүүсийн амьдарч ажиллаж байгаа, хэрэв нас барсан бол урьд нь амьдарч ажиллаж байсан аймаг, хот, яам, улсын хороо, тусгай газрууд болон холбогдох байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах;

в) улс төрийн хилс хэрэгт шийтгүүлээд цагаатгагдсан хүмүүсийн БНМАУ-ын баатар, ардын болон улсын гавьяат цол, одон медаль, цэргийн дээд цолыг сэргээх асуудлыг эрэлт хүсэлтийг нь үндэслэн судлан шийдвэрлүүлж байх;

г) ард иргэдээс хэлмэгдэгсдийн асуудлаар гаргасан өргөдөл, эрэлт хүсэлтийг хүлээн авч барагдуулах ажлыг зохион байгуулах;

д) улс төрийн хилс хэрэгт ял шийтгүүлээд цагаатгагдсан хүмүүсийн хураагдсан эд хөрөнгө, тэтгэвэр, тэтгэмжтэй холбогд-

сон эрвэт хүсвэтийг холбогдох байгууллагууд хэрхэн шийдвэрлэж байгаад хиналт гарна;

е) цагаатгалын ажлын дийцэг болон түмэнд нэвчлэх гэмтэй зохион байгуулах;

ж) улс төрийн эхлэс хэргийг хэлмэгдэгсдийн дургамлыг мөнхжүүлэх талаар гэрч байгаа гэмтэй судлын эхлэс арга тэмцлийг авахуулахаар эрх бүхий байгууллаагад оруулах.

9. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс дор дурдсан эрх эдвэл:

а) улс төрийн хэргийг эхлэс шийтгэгдэгсдийг цагаатгах асуудлаар БНМАУ-ын Ерөнхийлөгч, төрийн эрх барих дээд байгууллаага, Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг яам, улсын хороо, тусгай газар, аймэг, хотын гүйцэтгэх захиргаанд шалган, тэдгээрийн биелэлтийг хангуулах;

б) үйл ажиллагаатаа явуулахад шаардагдах мэдээ судалгаа, баримт бичиг, тодорхойлолт, бусад материалыг яам, улсын хороо, тусгай газар, аймэг, хотын гүйцэтгэх захиргаа, холбогдох байгууллаага, албан тушаалтан, иргэдээс шаардан гаргуулах ажил;

в) улс төрийн эхлэс хэргийг тэмгэж хэлмэгдсэн хүмүүсийн асуудлыг үргэлжлүүлэн судлаж цагаатгах ажлыг орон нутгийг удирдан зохион байгуулах салбар комиссыг яам, хотын Ардын Хурлын Тэргүүнэгчдийн дэргэд байгуулаж ажиллуулах;

г) хэлмэгдэгсдийн талаар судлаж, түүхэн үнэнийг тэгтгэл, нэр төрийг сэргээх зэрэг асуудлаар салбар комисс, ажлын хэсэг байгуулаж ажиллуулах;

д) улсын комиссын аппаратын орон тоо, цаалигний санг батлах;

е) улсын комиссын аппаратын ажилтнуудыг ажилд томилж, ажлаас чөлөөлөх;

ж) улс төрийн хэргийг эхлэс шийтгэгдэгсдийг цагаатгахтай холбогдсон асуудлаар холбогдох байгууллаага, албан тушаалтны сонгогч мэдээллийг тэвчлэх зөвлөлийг, заалт чиглэл өгөх.

БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ

991 оны 3 дугаар  
арын 26-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

ШАШНЫ АСУУДАЛ ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛ  
БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал  
эрхлэх зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

1. Гүржавын АХАГВА-  
СҮРЭН — Философийн ухааны дэд эр-  
дэмтэн, шашны асуудал эрх-  
лэх зөвлөлийн зохицуулагч
2. Сандагийн БАЯН-  
ЦАГААН — Монголын сүсэгтний хо-  
лооны тэргүүн
3. Шагдарын БИРА — Академич, түүхийн ухааны  
доктор, Олон улсын монгол  
судлааны холбооны ерөнхий  
нарийн бичгийн дарга
4. Очирбатын ДАШ-  
БАЛБАР — ХААЯ-ны ажилтан, зохиолч
5. Дандарын ЕНДОН — Хэд бичгийн ухааны доктор,  
Хэд, зохиолын хүрээлэн-  
гийн захирал
6. Гэлэгжамцын  
ЛУВСАНЦЭРЭН — Философийн ухааны дэд  
эрдэмтэн, Азийн буддис-  
туудын энхтайвны бага хур-  
лын ерөнхий нарийн бич-  
гийн дарга
7. Кадырын САИРААН — Монголын мусульманы ний-  
гэмлэгийн тэргүүн
8. Гүнжийн СҮХБААТАР — ШУА-ийн Зүүн-Хойт Ази  
судлааны төвийн эрдэм  
шинжилгээний ахлах ажил-  
тан

9. Ахаарангийн ТЭРБИШ — МУИС-ийн хэл шинжлэ-  
лийн тэнхимийн багш
10. Ахамсүрэнгийн  
ХҮРЭЛБААТАР — Хэл бичгийн ухааны дэд  
эрдэнтэн, Хэл, зохиолын  
хүрээлэнгийн секторын эрх-  
лэгч
11. Далантайн ЦЭРЭН-  
СОДНОМ — Хэл бичгийн ухааны доктор,  
Хэл, зохиолын хүрээлэн-  
гийн эрдэм шинжилгээний  
төргүүлэх ажилтан
12. Дашийн ЧИМИД-  
РЭГЗЭН — Өндөр настан
13. Дагвын ЧОЙЖИЛ-  
СҮРЭН — БНМАУ-ын гавьяат багш

Хоёр, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуу-  
дал эрхлэх зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

Гуран, Шагдарын Бираг Ерөнхийлөгчийн дэргэдэх эрдэмтний  
зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАА

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны  
3 дугаар сарын 26-ны өдрийн 60 дугаар  
зарлигийн хавсралт

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ДЭРГЭДЭХ ШАШНЫ АСУУДАЛ ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛААХ ЖУРАМ

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны асуудал эрхлэх зөвлөл нь төр, шашны харилцааг зохицуулах, шашны, сүм ийдийн талвархи төрийн бодлого, шийдвэрт эрдэмтэн, сэхээтэн, аншартан болон сүсэгтэн оюуны санга бодлыг тусгаж байх зорилго бүхий орон тосны бус зөвлөлдөх байгууллага мөн.

2. Зөвлөл нь шашны түүх, соёл, гүн ухаан, утга зохиол, одон урхай зэрэг дорно дахины ард түмнүүдийн уламжлалат мэдлэг хааны салбараар ажилладаг нэр хүндтэй эрдэмтэн, мэргэжилтэн, шашны уламжлалыг сайн мэдэх ахмад сэхээтэн, өндөр настнаас бүрдэнэ.

3. Зөвлөл, түүний гишүүд дор дурдсан үндсэн чиглэлийн ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

— төр, шашны болон шашин хоорондын харилцааг зохицуулах, төр шашны бусад байгууллагатай хамтран ажиллах, сангаартнуудын иргэний ба хөдөлмөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хууль зүйн баталгааг хүний эрхийн нийтлэг зөрчлөлд нийүүлэн боловсронгуй болгох, иргэдийн аливаа шашныг шүтэх, шүтэх эрх чөлөөг хамгаалах, шашны хүмүүнлэг нигүүлсэнгүйн эвнийг сэргээн төлөвшүүлэх, мэдлэг ухааны төрөл бүрийн салбараар шашны хүрээнд хуримталсан өв, ёс заншлын дэвшилтэт амжиллыг бүтээлчээр эзэмшин хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

— төр засаг, сүм хийд бие биений дотоод хэрэгт үл оролцох эрхчмыг хэрэгжүүлэн, сүм хийд нөвх, шашны дацан, сургууль байгуулах асуудлаар төрийн бодлогод зохицсон арга хэмжээг элбэсруулан хэрэгжүүлэх;

— сүм хийдийн хурал номын үйл ажиллагааг дэмжих зорилгоор музей, номын сангуудад буй шашны уншлага, зан үйлийн эм, хөлгөн судар, бурхан тахилын зүйлсээс соёлын үнэт сан мрөгт үл хамаарах хэсгийг хурлын газар шилжүүлэх зэрэг арга хэмжээг төрийн зүгээс авч хэрэгжүүлэхэд туслаацаа үзүүлэх;

— шашны судаллын зангилааа чухал асуудлуудаар онол-аргаүй, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, яриаллага зохион байгуулах, төр, шашны харилцааны онол, практикийн зарим хал асуудлыг судлан боловсруулах;



— төр, шашны харилцаа, шүтэх ба эс шүтэх эрх чөлөөний асуудлаар гадаад, дотоодод нийтлэгдсэн эрдэм шинжилгээний ном бүтээл, хууль дүрмүүдийг эмхтгэн цуглуулаж авчлах хэрэг-лэгдэхүүн бүрдүүлэх;

4. Зөвлөлийн гишүүд шашин, сүм хийдийн асуудалтай биечлэн танилцаж, дам хуврага нарын санаа бодлыг сонсож, холбогдох арга хэмжээг авахыг зөвлөх, төрөөс шашны талаар баримтгаж буй бодлогыг ухуулан сурталчлах, зарлиг, шийдвэр биелүүлэхийг шаардах үүрэгтэй. Шашны ёс горимыг гуйвуулах, санваартны нэр хүндийг урвуулан ашиглах, төр шашны эрх ашигт харшлах аянгаа илрэлтэй тэмцэл хийнэ.

5. Зөвлөлөөс санаа, зөвлөмж боловсруулан гаргахдаа гишүүдийн олонхийн санаад тулгуурлах, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэх ардчилсан зарчмыг тууштай баримтлана. Зөвлөлийн гишүүд нь зөвлөлдөн буй асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байна. Зөвлөлийн шийдвэрийг гишүүн бүр хүндэтгэн биелүүлж, мөрдлөг болгоно. Санаа зөрсөн асуудлаархи бусдын байр суурь, үзэл бодлыг гуйвуулж, өөрийн ойлголтод таацуулан сурталчлахыг хориглоно.

6. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагын ажигтан, эрдэмтдийг оролцуулсан ажлын хэсгийг тодорхой асуудлаар байгуулан ажиллуулана.

7. Зөвлөлийн ба ажлын хэсгийн үйл ажиллагааг Зөвлөлийн зохицуулагч удирдаж зохион байгуулна. Зохицуулагч нь БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх байна.

8. Зөвлөлийн зохицуулагч буюу гишүүдийг Ерөнхийлөгчийн захирамжаар томилж, өөрчилнө. Зөвлөлийн гишүүд нь БНМАУ-ын Ерөнхийлөгчийн гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй, нэрийн хуудастай байна.

9. Зөвлөл нь бичиг хэрэг, аж ахуй, санхүүгийн хувьд БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газарт харьяалагдана.

10. Зөвлөл нь төр, шашны харилцааны асуудлаар зөвлөлдөх, туршлага судлах зорилгоор гадаадын нэр хүндтэй эрдэмтэн, санваартнуудыг урьж болно.

11. Зөвлөлийн гишүүд тухайн боловсруулж буй асуудалтай холбогдсон тоо баримт, мэдээ хэрэглэгдэхүүнийг зохих байгуулагаас гаргуулан авч, танилцах эрхтэй.

12. Зөвлөлийн гишүүн ажлын шаардлага гарсан үед БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын албан томилолтоор гадаад, дотоодод явж байна.

13. Зөвлөлийн үйл ажиллагааны явц, үр дүнг Ерөнхийлөгчийн хөвдөр, мэдээллийн албанаас эрхлэн албан ёсоор мэдэвчлнэ.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИНЛӨГЧИЙН ЗАРИЙГ**

991 оны 3 дугаар  
арны 28-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

**АМЬСГАЛ БООГДУУЛАХ, НУЛИМС АСГАРУУЛАХ  
ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХИЙГ  
ХОРИГЛОХ ТУХАЙ**

1. Сүүлийн үед зарим иргэд гадаад улсаас амьсгал боогдуулах, нулимс асгаруулах үйлчилгээтэй тусгай хэрэгслийг хувийн сурмаар авчирч зориулалтын бусар ашиглах явдал удаа дараа арч бусдын эрүү мэндэд хор хохирол учруулж байгааг харгалан дор дурдсан тусгай хэрэгслийг цагдаагийн ерөнхий газрын өншөөрөлгүйгээр гадаадаас авч ирэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, худалдан авах, хэрэглэхийг хориглосугай:

а) амьсгал боогдуулах, нулимс асгаруулах үйлчилгээтэй хийн бодис, түүгээр цэнэглэсэн буу, бусад хэрэгсэл;

б) цагдаагийн байгууллагын зэвсэглэлд зориулсан тусгай хэрэгслүүд.

2. Энэ зарлигийн нэгдүгээр зүйлийн заалтыг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шиндэггүй бол тусгай хэрэгслийг хураан авч, эм буруутай этгээдийг 500—3000 төгрөгөөр торгох буюу шүүгийн тогтоолоор 10—30 хоног хүртэл хугацаагаар баривчлан айсугай.

3. Зарлигийн нэгдүгээр зүйлд заасан тусгай хэрэгслийг эвэмтнэж байгаа сэжиг бүхий хүмүүст үзлэг хийж, илэрсэн зүйлийг урлах, гэм буруутай хүнд торгууль оногдуулах, энэ зарлигт заагч баривчлах арга хэмжээг авахуулахаар материалыг шүүгчид илжүүлэх эрхийг цагдаагийн болон гаалийн байгууллагад олзсугай.

4. Энэ зарлигийг БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэд, аль ч улсын иргэн биш хүмүүст нэгэн адил хамааруулсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 4 дүгээр

Дугаар 62

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

хот

**ОЛОН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ЗӨРЧИЖ  
ТАНХАЙРАГЧДАД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫГ  
ЧАНГАТГАХ ТУХАЙ**

Олон нийтийн газар хэрүүл маргаан, зодоон үүсгэх, бусдыг өдөөн хоргоох болон айлган сүрдүүлэх, байр, орон сууцанд бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, үйлчилгээний газрын журам гажуудуулах зэргээр нийгмийн хэв журмыг зөрчиж танхайрсан, түүний улмаас барилга байгууламж, нийтийн өзөмшлийн эд хөрөнгийг гэмтээсэн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол өвдөж гэмтээсэн зүйлийн үнийг төлүүлж, шүүгчийн тогтоолоор, суурин шүүгчгүй газарт сум, хорсоны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны захирамжаар 10—30 хоног хүртэл хугацаагаар баривчлах буюу 3 сар хүртэл хугацаагаар эвсэн хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэн хөдөлмөрийн хөлсний 20 хүртэл хувийг улсын орлогод суутгаж байсугай. Энэ арга хэмжээг авах шаардлагагүй гэж үзвэл шүүгч, цагдаагийн байгууллагын нийгмийн хэв журам сахиулах, хянан шалгах эрх бүхий албан тушаалтан, сум, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас уг этгээдийг 400—2000 хүртэл төгрөгөөр торгож байсугай.

2. Зарлигийн нэгдүгээр зүйлд эвсэн зөрчлийг согтуугаар буюу бүлэглэн үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 15—45 хоног хүртэл хугацаагаар баривчлах буюу 3—6 сар хүртэл хугацаагаар эвсэн хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 1000—2500 төгрөгөөр торгох арга хэмжээ авч байсугай.

3. Энэ зарлигт эвсэн захиргааны арга хэмжээг 16 ба түүнээс дээш насны хүмүүст авна. Хэрэв уг зөрчлийг 14—16 хүртэл насны хүүхэд үйлдвэл түүний эцэг буюу ах, эсрэн хамгаалагчийг зарлигийн нэгдүгээр зүйлд эвсэн хэмжээгээр торгож, зөрчил гаргасан хүүхдийг сургууль, хамт олноор нь заавал хэлэлцүүлж хүмүүжүүлэх арга хэмжээ авч байсугай.

4. Хутга, мэс, бусад зүйлийг хот, суурин газарт эвсгийн чанартайгаар биедээ авч явахыг хориглосугай. Энэ заалтыг зөрчсөн гэм буруутай этгээдээс уг зүйлийг хурал авч, 300—1000 төгрөгөөр торгох буюу энэ зарлигийн нэгдүгээр зүйлд эвсэн баривчлах арга хэмжээ авч байсугай.

5. Энэ зарлигт заасан зөрчлийн тухай гомдоо, мэдээллийг жагдаагийн байгууллага, сум, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа 3 хоногийн дотор, шүүгч материалыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор тус тус шийдвэрлэж байсугай.

6. Нийгмийн хэв журам зөрчиж танхайрагчидтай тэмцэх жилд нутаг дэвсгэрийн улс, хоршоолоо, олон нийтийн байгууллага, үйлдвэр аж ахуйн газар, хөдөлмөрийн хамт олон, хөдөлгөөрчдийг өргөнөөр татан оролцуулах талаар үр нөлөөтэй тодорхой ажла зохиож байхыг орон нутгийн Ардын Хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргаанд даалгасугай.

7. Олон нийтийн хэв журмыг сахиулах ажилд оролцсон ирээднийг урамшуулахад зориулан төсвийн орлогоос зохих хөрөнгийг зарцуулж байх өрхийг орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд олгосугай.

8. Зарлигийн дагуу баривчилсан этгээдийг нийгмээс тусгаарлан тогтоосон хэмжээний ажла хийлгэж, уг этгээдийг тусгай ийранд байлгаснаас гарсан бүх зардалыг хөдөлмөрийн хөдснөөс нь суутган авч, хэрэв өөрийн буруугаар хөдөлмөр хийгээгүй бол ихэн төлүүлж байх журам тогтоосугай.

9. Зөрчил гаргасан этгээд оногдуулсан торгуулийг тогтоосон угацаанд нь төлөхгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар гаргуулж байсугай.

10. Энэ зарлигийг биелүүлэх заавар гаргахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

11. Зарлигт заасан эрга хэмжээ явагдсан этгээдийн талаар үүний ажиллаж сурч байгаа байгууллагад мэдэгдэж, хөвлээ, мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд тодорхой мэдээлэл жигшүүдэх ажлыг зохиож байсугай.

12. Энэ зарлиг гарсантай холбогдуулан «Танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 111 дүгээр зарлигийн 1—9 дүгээр зүйл, «Хутга, мэс, бусад гүйлийг зөвсгийн чанартайгаар биедээ авч явахыг хориглох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 91 дүгээр зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 4 дүгээр

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

Дугаар 63

ХОТ

**ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ХҮНСНИЙ  
ЗҮЙЛИЙГ ХУВААРИЛАХ, БОРЛУУЛАХ АЖЛЫГ  
ЖУРАМЛАХ, ДАМЫН НАЙМАА ХИЙГЧДЭД  
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ  
ТУХАЙ**

1. Өргөн хэрэглээний бараа, хүнсний зүйлийн хуваарилалт, борлуулалтын шударга зарчмыг гажуудуулж барааны зохиомол хомсдолд оруулж байгаа зүй бус явдлыг таслан зогсоох талаар хөдөлмөрчдөөс гаргаж байгаа санал, хүсэлтийг харгалзан:

а) жижиглэн худалдаалах бараа, хүнсний зүйлийг улсын үйлдвэрийн газар, худалдаа, нийтийн хоолны байгууллагын агуулах, баазас худалдах;

б) бараа, хүнсний зүйлийг тээвэрлэх явцад дур мэдэн худалдах буюу хувьдаа худалдан авах;

в) улсын худалдааны шугамаар хүн амд жижиглэн худалдаалахаар дэвгүүр, мухааг, худалдаа, нийтийн хоолны бусад цэг саалбарт хуваарилаан худалдагчид шилжүүлсэн барааг худалдан авагчдаас нууж нөөцлөх;

г) хөдөлмөрчдөд картаар олгоход зохих барааг хуваарьтай эзэнд нь олгохгүй байх, хуваарьт бараагаа аваагүй нөхцөлд дахин хуваарилахгүйгээр бүртгэл хяналтаас гадуур худалдахыг тус тус хориглосугай.

2. Энэ зарлигийн нэгдүгээр зүйлийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан шийтгэл оногдуулж байсугай:

а) нэгдүгээр зүйлийн а, б заалтыг зөрчсөн улсын үйлдвэрийн газар, худалдаа, тээвэр, нийтийн хоолны байгууллагын ажилтанг 1000—2000 төгрөгөөр, тэдгээртэй хуйвалдаж уг барааг хууль бусаар худалдан авсан этгээдийг 1000 хүртэл төгрөгөөр торгож, барааг хурал авч улсын орлого болгоно. Хэрэв барааг хурал авах боломжгүй бол худалдсан этгээдээс үнийг гаргуулж улсын орлогод оруулна;

б) нэгдүгээр зүйлийн в, г заалтыг зөрчсөн худалдагч, нярав, дэлгүүрийн эрхлэгч, бусад ажилтанг 500—1500 төгрөгөөр торгоно;

в) дээрх зөрчлийг давтан гаргасан буюу бүлэглэн үйлдсэн бол энэ зүйлд дурдсан торгуулийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмж оногдуулна.

3. Зөрчил гаргасан үйлдвэрийн газар, худаадаа, нийтийн хоолны байгууллаагмын ажиагчид уг ажилд нь ажлаагуулах боломжгүй гэж үзвэл тухайн байгууллаагмын захиргаа хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу түүнийг ажлаас халах хүртэл арга хэмжээ авч байсугай.

4. Эх орны үйлдвэрийн болон гадаад орноос улсын худаадаагаар авсан өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүнийг сууль бусаар ашиг хонжоо олох зорилгоор худаадан авч дамласан этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 1000—3000 төгрөгөөр торгох буюу 10—30 хоног хүртэл хутагаагаар баривчлах арга хэмжээ оногдуулж, дамлан худаалдсан болон дамлахаар бэлтгэсэн бараа, олсон орлогыг тус тус хурааж улсын орлого болгож байсугай.

5. Хот, сууринд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллаагмын зөвшөөрсөн цагаас бусад газарт хувийн журмаар судалдаа хийсэн гэм буруутай этгээдийг 300—1000 төгрөгөөр торгож, худалдаалахаар авч явсан зүйлийг хураан авч улсын орлого болгож байсугай.

6. Энэ зарлигт дурдсан торгуулийг цагдаагийн байгууллаагмын болон улсын худалдааны байцаан шалгах эрх бүхий албан тушаалтан, сум, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, барибчлах арга хэмжээг шүүгч, суурин шүүгчгүй газарт сум, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа оногдуулж байсугай.

7. Зөрчил гаргасан этгээд оногдуулсан торгуулийг тогтоосон угацаанд нь төлөхгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар гаргуулж байсугай.

8. Зарлигт заасан арга хэмжээ авагдсан этгээдийн талаар үүний ажиллаж, сурч байгаа байгууллагад мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тодорхой мэдээлэн жигшүүлэх ажил зохиож байсугай.

9. Зарлигийн биелэлтэд хяналт тавих ажилд хөдөлмөрчдийн ус дамжлагийг авч, энэ ажилд оролцсон иргэдийг урамшуулахад ориулан төсвийн орлогоос зохих хөрөнгийг зарцуулж байх эрнийг орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаадад олгоугай.

10. Энэ зарлигт гарсантай холбогдуулан «Дамын худалдаа нийсэн этгээдэд хүлээлгэх захиргааны хариуцлагыг хүчтэй бол-

гох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 62 дугаар зарлигийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИГЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 4 дүгээр

Дугаар 68

Улаанбаатар

сарын 3-ны өдөр

ХОТ

### ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ХҮНИЙГ ШАГНАХ ТУХАЙ

Дээрхийн нэгдүгээр гэмт хэрэг удаа дараа үйлдсэн, зэвсэглэсэн бүлэг өтгээдүүдийг илрүүлэн баривчлахад эрэлхэг зориг, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж, цагдаагийн байгууллагын ажлалтын үүргээ нэр төртэй биелүүлдснийг үнэлж дор дурдсан хүмүүсийг БНМАУ-ын одон, медалиар шагнасугай:

#### ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Хасгаагийн ТӨМӨР-  
БААТАР

— Улаанбаатар хотын Хайлаастын цагдаагийн хэлтсийн төлөөлөгч, ахлах дэслэгч

2. Дашнямын ЧИНЗОРИГТ — Цагдаагийн ерөнхий газрын III тусгай тасгийн ахлах байцаагч, ахлах дэслэгч

#### ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дашзэвэгийн  
ГАНХУЯГ

— Улаанбаатар хотын Хайлаастын цагдаагийн хэлтсийн төлөөлөгч, дэслэгч

2. Баатарын БОЛДБААТАР — Цагдаагийн ерөнхий газрын  
III тусгай тасгийн цагдаа

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРИГ

991 оны 4 дүгээр

Дугаар 69

Улаанбаатар

орны 3-ын өдөр

ХОТ

Б. ЦЭНДСҮРЭНГ «ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР  
ШАГНАХ ТУХАЙ

Гаалын аюулаас хүүхдийн амь аварч иргэнийхээ үүргийг нэр  
эртэй биелүүснийг үнэлж, Ховд аймгийн Мөст сумын Халзан  
ошуу бригадын өндөр настан Бормагнайн Цэндсүрэнг «ШУ-  
ДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ



**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 5 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар  
хот

**ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ «ШУДАРГА ЖУРАМ»  
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Усны аюулаас хоёр хүний амь аварсан Сэлэнгэ аймгийн 10 жилийн I дунд сургуулийн 8 дугаар ангийн сурагч Чулууунбаатарын БАТНЯМ, мөн аймгийн Сүхбаатар хотын III хорооны иргэн Чимэддэрэнгийн ГАНСҮХ, Тэгшээгийн БАТЗОРИГ нарыг «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 5 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

**ДАМДИНЖАВЫН ГАНХҮҮГ ШУДАРГА ЖУРАМ  
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Гэндэгийн ослоос хүний амь аварсан Эрдэнэт хотын Төв га унтраах ангийн гал сонгогч Дамдинжавын ГАНХҮҮГ «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

991 оны 5 дугаар

Дугаар 76

Улаанбаатар

арын 6-ны өдөр

ХОТ

**ТОВУУДОРЖИЙН БЯМБАДООГ ШУДАРГА ЖУРАМ  
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Гал түймрийн аюулаас 2 хүүхдийн амь аварч иргэнийхээ үүр-  
ийг нэр төртэй биелүүлснийг үнэлж Эрдэнэт хотын Цагдаагийн  
элтсийн саргийлэгч Товуудоржийн БЯМБАДООГ «ШУДАР-  
ГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

991 оны 5 дугаар

Дугаар 77

Улаанбаатар

арын 6-ны өдөр

ХОТ

**ЗАРИМ СУРАГЧДЫГ «ШУДАРГА ЖУРАМ»  
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Эр зориг, авхаалж самбаа гарган усны аюулаас 4 хүний амийг  
варч иргэний үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Хэнтий  
иймгийн Биндэр сумын 10 жилийн дунд сургуулийн 6 дугаар ан-  
гийн сурагч Дамдинжавын МӨНХЖАРГАЛ, мөн сургуулийн  
дүгээр ангийн сурагч Дагвын ДУГАРРАГЧАА нарыг «ШУ-  
ДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРИЛГ**

1991 оны 5 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар  
хот

**ЗАРИМ ХҮМҮҮСТ БНМАУ-ЫН ГАВЬЯАТ  
ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Түлш, эрчим хүчний салбарт үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой өндөр амжилт гаргаж байгааг үнэлж дор дурдсан хүмүүст БНМАУ-ын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

**БНМАУ-ЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ  
АЖИЛТАН ЦОЛООР:**

Сосорбарамын ЭРДЭНЭЭ — Дархан хотын дулааны цахилгаан станцын гагнуурчин

**БНМАУ-ЫН ГАВЬЯАТ УУРХАЙЧИН ЦОЛООР:**

- Чимээгийн СЭНГЭЭРЭЙ — Шарын голын нүүрсний уурхайн өрмийн машинч
- Хавалхатын КАДАС — Налайхын нүүрсний уурхайн ашиглаалтын нэгдүгээр хэсгийн засварчин
- Сумъяагийн ДҮГЭРЖАВ — Багануурын нүүрсний уурхайн Белазын жолооч

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 5 дугаар

Дугаар 79

Улаанбаатар

арын 7-ны өдөр

ХОТ

**Д. ДАНЗАНД БНМАУ-ЫН СОЕЛЫН ГАВЬЯАТ  
ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Сүхбаатарын хөшөөг барьж байгуулах, Цогт тайж киноны гол үрүүдийн хувцасыг хийх, Гандантөгчнанин, Эрдэнэзуу, Амар-Заясгалан хийдийг засварлах ажилд ур чадвар авьяас билгээ тайчлан ажиллаж үндэсний соёлын өв уламжлалыг сэргээхэд ирүүлсэн хувь нэмрийг үнэлж, Гандантөгчнанин хийдийн лам Дугаржавын ДАНЗАНД БНМАУ-ЫН СОЕЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН цол олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 5 дугаар

Дугаар 80

Улаанбаатар

арын 7-ны өдөр

ХОТ

**С. БАЛДОРЖИД БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН  
БААТАР ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Харнуусан тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээг чанартай ийж, ашиглаалтын хэмнэлттэй горимоор тогтвортой ажиллуулж, рчим хүч үйлдвэрлэх ажилд гарамгай амжилт гаргаж байгааг нэлж Улаанбаатар хотын дөрөвдүгээр цахилгаан станцын тур-ины машинч Самбын БАЛДОРЖИД БНМАУ-ЫН ХӨДӨЛ-

**МӨРИЙН БААТАР** цол олгож **СҮХБААТАРЫН** одон,  
«**АЛТАН СОЕМБО**» тэмдгээр шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 5 дугаар

Дугаар 81

Улаанбаатар

сарын 7-ны өдөр

хот

**НӨХӨР Ж. ДАГВАДОРЖИД БНМАУ-ЫН  
ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилга байгууламжийг хугацаанаас нь өмнө чанартай барьж ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг чадамгай зохион байгуулж, хөдөлмөрийн гарамгай амжилт гаргаж байгааг үнэлж, Эрчим хүчний техник туслаалцааны барилга угсралтын трестийн мастер **Жамбалын ДАГВАДОРЖИД БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР** цол олгож, **СҮХБААТАРЫН** одон, «**АЛТАН СОЕМБО**» тэмдгээр шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ